

**“Хүнс, өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт,
зах зээлийг бусад эдийн засагтай харьцуулах нь”**

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

(Зарим тоо мэдээллийг 2015 оны 2 сард 2014 оны гүйцэтгэлээр шинэчлэв.)

Захиалагч: Үндэсний Аудитын Газар

Гүйцэтгэсэн:

Судалгааны багийн ахлагч ,МУИС-ын ШУ-ны Сургуулийн Эдийн засгийн тэнхмийн багш
доктор, профессор Б.Батмөнх (batmunkhb2014@gamil.com)

Улаанбаатар

2014оны 11 сар

АГУУЛГА

Өмнөх үг

Бүлэг 1.Хэрэглээний үнийн индексээр тооцсон болон суурь инфляцийн өсөлтийн чиг хандлага, бусад улс орнуудтай зэрэгцүүлсэн байдал

- 1.1. Хэрэглээний үнийн индексээр (ХҮИ)тооцсон инфляцийн өсөлтийн чиг хандлага
- 1.2. Суурь инфляцийн өсөлт
- 1.3. Манай орны инфляцийн өсөлтийг бусад улс орнуудтай зэрэгцүүлсэн байдал
- 1.4. Дэлхийн болон Монголын зах зээл дэх хүнсний барааны үнийн өөрчлөлтийн харьцуулалт

Бүлэг 2.Инфляцид үзүүлсэн гол хүчин зүйлийн шинжилгээ, үүнээс валютын ханшны инфляцид үзүүлсэн нөлөөлөл

- 2.1. Инфляцид нөлөөлөгч голлох хүчин зүйлс
- 2.2.Хүнсний бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт болон улирлын хэлбэлзэлийн инфляцид үзүүлсэн нөлөө
- 2.3. Бусад субъектив хүчин зүйлс
- 2.4. Валютын ханшны инфляцид үзүүлсэн нөлөөлөл

Бүлэг 3. Үнийн өсөлтийг бууруулах талаар төр, засгийн зүгээс сүүлийн 3 жилд гарсан тогтоол, шийдвэр, түүний хэрэгжилт

- 3.1.Шатахууны жижиглэнгийн үнийг тогтворжуулах дэд хөтөлбөрийн хэрэгжилт
- 3.2.Өргөн хэрэглээний импортын бараа, бүтээгдэхүүний өртгийг бууруулах дэд хөтөлбөрийн хэрэгжилт
- 3.3.Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дэд хөтөлбөрийн хэрэгжилт
- 3.4.Барилгын салбарыг дэмжих, улмаар орон сууцны үнийг тогтворжуулах дэд хөтөлбөрийн хэрэгжилт
- 3.5.“Нүүрсний аюулгүйн нөөц бүрдүүлэх, түлш, эрчим хүчний салбарын өвөлжилтийн бэлтгэл хангах, эрчим хүчний үнэ, тарифыг тогтворжуулах” дэд хөтөлбөрийн хэрэгжилт

Бүлэг 4. Бусад улс орнуудад үнийг тогтворжуулах талаар авдаг арга хэмжээ, туршлага

- 4.1. Үнийг тогтворжуулах стратеги
- 4.2.Энэтхэгийн үнэ тогтворжуулах сан
- 4.3. Канадын хөдөө аж ахуйн орлого тогтворжуулах хөтөлбөр

4.4. Тайваны хөдөө аж ахуйн бодлого

Бүлэг 5.Дүгнэлт, санал, зөвлөмж

5.1. Дүгнэлт

5.2. Санал, зөвлөмж

Товчилсон тэмдэглэл

ХҮИ	Хэрэглээний үнийн индекс
ДНБ	Дотоодын Нийт Бүтээгдэхүүн
ҮСХ	Үндэсний Статистикийн Хороо
БХБЯ	Барила, хот байгуулалтын яам
МИК	Монголын ипотекийн корпорац
ОУВС	Олон Улсын Валютын Сан
АХБ	Азийн Хөгжлийн Банк
WEO	World Economic Outlook

Зургийн жагсаалт

Зураг 1.1. Хэрэглээний үнээр тооцсон инфляцийн 2000-2014 оны жил бүрийн өсөлт, хувь

Зураг 1.2. Хэрэглээний үнийн индексээр тооцсон инфляцийн суурь 2000 онтой харьцуулсан өсөлт, хувиар

Зураг 1.3. ДНБ болон ХҮИ-ийн жил бүрийн өөрчлөлтийн хувь

Зураг 1.4. ДНБ болон ХҮИ-ийн суурь онтой харьцуулсан өсөлт, 2000=1, дахин

Зураг 1.5. ХҮИ болон түүний 13 сарын шаталсан дундаж өсөлт, хувиар

Зураг 1.6. Улаанбаатар хотын хэрэглээний үнийн индексээр тооцсон болон суурь инфляцийн сар бүрийн өсөлт, хувиар

Зураг 1.7. Улаанбаатар хотын хэрэглээний үнийн индексээр тооцсон болон суурь инфляцийн суурь үетэй харьцуулсан өсөлт, хувиар

Зураг 1.8. Дэлхийн болон Монголын зах зээл дэх хүнсний бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтийн хувь, 2005=100

Зураг 1.9. Дэлхийн болон Монголын зах зээл дэх үхрийн махны үнийн өсөлтийн хувь, 2005=100

Зураг 1.10. Дэлхийн болон Монголын зах зээл дэх гурилын үнийн өсөлтийн хувь, 2005=100

Зураг 1.11. Дэлхийн болон Монголын зах зээл дэх цагаан будааны үнийн өсөлтийн хувь, 2005=100

Зураг 2.1. Мөнгөний нийлүүлэлт (M2) болон ХҮИ-ийн жил бүрийн өсөлтийн хувь

Зураг 2.2. Нэгдсэн төсвийн нийт зардал, мөнгө M1 болон M2, ХҮИ-ийн суурь онтой харьцуулсан өсөлт, 2000=1, дахинаар

Зураг 2.3. Улсын нэгдсэн төсвийн 2010-2014 оны орлого, зарлага, тэнцэл, тэрбум төгрөг

Зураг 2.4. ХҮИ болон хүнсний бүтээгдэхүүний үнийн жил бүрийн өөрчлөлт, 1995-2014 он, хувиар

Зураг 2.5. ХҮИ болон хүнсний бүтээгдэхүүний үнийн суурь онтой харьцуулсан өсөлт, дахин, 1990=1

Зураг 2.6. Хэрэглээний үнийн болон хүнсний бүтээгдэхүүний үнийн сар бүрийн өөрчлөлт, хувиар, 2006 оны 1 сараас 2014 оны 8 сар

Зураг 2.7. Хэрэглээний үнийнболон хүнсний бүтээгдэхүүнийүнийн улирлын индекс

Зураг- 2.8.Ам.доллрын сарын дундаж албан ханш, төгрөг

Зураг-3.1. Хүн амын гар дээр очсон шатахууны жижиглэнгийн үнийн суурь үетэй (2012 оны 9 сар) харьцуулсан өсөлт, хувиар, 2012.IX=100

Зураг-3.2. Хүн амын гар дээр очсон махны жижиглэнгийн үнийн суурь үетэй (2012 оны 12 сар) харьцуулсан өсөлт, хувиар, 2012.XII=100

Зураг-3.3. Хүн амын гар дээр очсон гурилын жижиглэнгийн үнийн суурь үетэй (2012 оны 12 сар) харьцуулсан өсөлт, хувиар, 2012.XII=100

Зураг 3.4. Цементийн үнийн өөрчлөлт,2000=100, хувиар

Зураг-3.5. Цахилгаан, дулаан, түлшний үнийн суурь үетэй (2013 оны 7 сар) харьцуулсан өсөлт, хувиар, 2013.VII =100

Хүснэгт, схемын жагсаалт

Хүснэгт 1.1. Зарим улс орнуудад суурь инфляцийг тооцдог аргууд

Хүснэгт-1.2. Шилжилтийн эдийн засагтай орнуудын ХҮИ-ээр тооцсон инфляцийн өсөлт,хувь, 2000=100

Хүснэгт-1.3.Хөгжингүй орнуудын ХҮИ-ээр тооцсон инфляцийн өсөлт, 2000=100

Хүснэгт-2.1. Хэрэглээний үнийн өсөлтөд импортын бараа бүтээгдэхүүний үнийн өөрчлөлтийн нөлөө

Хүснэгт 4.1. Үнэ тогтворжуулалтын стратегийн ABCD матриц

Хүснэгт 4.2 Энэтхэгийн үнэ тогтворжуулах сангийн онцлог

Хүснэгт 4.3. Тайваны ХАА-н бодлогын ерөнхий бүтэц

Схем 4.1.Үнэ тогтворжуулах хэрэгслүүдийн үр нөлөө

Схем 4.2. Канадын орлого тогтворжуулах хөтөлбөр дэх Засгийн газрын оролцоо

Өмнөх үг

Манай оронд сүүлийн 5 жилд инфляцийн түвшин тогтмол 2 оронтой тоогоор нэмэгдэж, хүн амын худалдан авах чадвар, амьжиргааны түвшинд ноцтой сөргөөр нөлөөлж ирсэн. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2012 онд 14 хувь, 2013 онд 12,5 хувь, 2014 онд 11 хувиар өссөн. Хэрэглээний үнийн индексээр тооцсон инфляцийн түвшин 2014 оны эцэст 2010 оны эцсийнхээс 56,9 хувиар нэмэгдээд байна. Энэ нь 2010 оны эцэст байсан 100 мянган төгрөг 2015 оны эхэнд ердөө 63,7 мянган төгрөг болсон гэсэн үг юм. Сүүлийн 5 жилд инфляци 100 мянган төгрөг тутмаас 36,3 мянган төгрөг буюу гуравны нэгээс илүүг нь шууд үнэгүйдүүлсэний улмаас хүн амын худалдан авах чадвар энэ хэмжээгээр буурсан юм.

Зах зээлийн эдийн засгийн нөхцөл дэх төрийн нэг чухал үүрэг бол макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах явдал байдаг. Инфляци нь манай орны макро эдийн засгийн тогтвортой байдалд муугаар нөлөөлж, улсын төсөв, валютын ханш, зээлийн хүү, цалин, ядуурлын түвшин гэх мэт эдийн засаг, нийгмийн хөгжлийн олон үзүүлэлтүүдэд хүчтэй сөрөг нөлөөг үзүүлж байна. Мөн инфляцийн өндөр өсөлт нь дотооддоо улс төр, эдийн засгийн тогтолцоонд итгэх итгэлийг бууруулж, гадаад талдаа шууд хөрөнгө оруулалтын урсгалд таагүй нөлөөлж байна. Ийм учраас төрийн зүгээс инфляцийн өсөлтийг хяналтандаа байлгах, түүний тогтворгүй их өсөлтийг хязгаарлахын тулд нэн тэргүүнд инфляцид нөлөөлж байгаа хүчин зүйлсийн талаар нарийн судалгаа, шинжилгэнд үндэслэсэн бодит мэдээлэлтэй байх нь зайлшгүй чухал юм.

Онолын хувьд болон практик амьдрал дээр инфляцийн өсөлтөд нөлөө үзүүлдэг олон хүчин зүйл байдаг бөгөөд энэ нь тухайн орны хөгжлийн түвшин, эдийн засгийн орчин нөхцөл, мөнгөний болон мөнгөний бус олон хүчин зүйлээс шалтгаалдаг.

Энэхүү судалгаанд манай орны инфляцийн өсөлтийн чиг хандлага, түүний өсөлтийг бусад улс орнуудтай зэрэгцүүлэн үзэж, инфляцийн өсөлтөд нөлөөлсөн зарим гол хүчин зүйлс, үүний дотор мөнгөний нийлүүлэлт, төсвийн зардал, хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлт, түүний нийлүүлэлтийн улирлын хэлбэлзэл, валютын ханшны өөрчлөлтийн нөлөөг тодорхойлж, Засгийн газар болон Монголбанкнаас хамтран хэрэгжүүлсэн үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хэрэгжилтэнд зохих үнэлгээ өгөх оролдлого хийлээ.

Энэхүү ажил нь үндсэн 5 бүлгээс бүрдэнэ. 1-р бүлэгт хэрэглээний үнийн индексээр тооцсон болон суурь инфляцийн өсөлтийн чиг хандлага, ХҮИ-ээр тооцсон инфляцийн өсөлтийг бусад улс орнуудтай зэрэгцүүлэн харуулав. Энд мөн дэлхийн болон Монголын зах зээл дэх хүнсний барааны үнийн өөрчлөлт, үүний дотор үхрийн мах, гурил, цагаан будааны үнийн өсөлтийг харьцуулан харуулав. 2-р бүлэгт мөнгөний нийлүүлэлт, төсвийн зардлын өсөлт, төсвийн алдагдал, хүнсний бараа, бүтээгдэхүүний үнэ, түүний нийлүүлэлтийн улирлын чанартай хэлбэлзэл зэрэг гол хүчин зүйлийн инфляцид үзүүлсэн нөлөөг авч үзэж, валютын ханшны өсөлт импортын барааны үнээр дамжин инфляцид хэрхэн нөлөөлснийг харуулав. 3-р бүлэгт үнийн өсөлтийг бууруулах талаар төр, засгийн

зүгээс сүүлийн 3 жилд гарсан тогтоол, шийдвэр, Монголбанк болон Засгийн газрын хамтран хэрэгжүүлж ирсэн үнэ тогтворжуулах дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн байдалд үнэлгээ өгсөн.


Төгсгөлийн 5-р бүлэг судалгаанаас гарсан үр дүн, дүгнэлт, санал зөвлөмжийг агуулсан болно.

Бүлэг 1.Хэрэглээний үнийн индексээр (ХҮИ)тооцсон болон суурь инфляцийн өсөлтийн чиг хандлага, бусад улс орнуудтай зэрэгцүүлсэн байдал

1.1.Хэрэглээний үнийн индексээр (ХҮИ)тооцсон инфляцийн өсөлтийн чиг хандлага

Манай орны хэрэглээний үнийн индексээр тооцсон инфляцийн түвшин сүүлийн 15 жилд ихээхэн тогтворгүй, үүний дотор сүүлийн 5 жилд тогтмол 2 оронтой тоогоор өсөж ирснийг доорх зургаас харж болно.

Зураг 1.1. Хэрэглээний үнээр тооцсон инфляцийн 2000-2014 оны жил бүрийн өсөлт, хувь




Эх үүсвэр: ҮСХ, Монгол Улсын Статистикийн эмхтгэл, 2005, 2012, 2013, 2014 оны 12 сарын статистикийн бюллетень

Зах зээлийн эдийн засгийн нөхцөл дэх төрийн эдийн засгийн бодлогын нэг чухал зорилго бол макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах явдал байдаг. Монголбанк “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2012 онд баримтлах үндсэн чиглэл”-дээ ХҮИ-ээр илэрхийлэгдэх инфляцийг нэг оронтой тооноос хэтрүүлэхгүй, 2013-2014 онуудад найман хувиас хэтрүүлэхгүй түвшинд байхаар УИХ-д оруулж батлуулсан боловч энэ нь амьдралд огт хэрэгжээгүйг дээрх зургаас харж болно. Монголбанк 2015 оны мөнгөний бодлогодоо инфляцийн өсөлтийг 7 хувиас хэтрүүлэхгүй байхаар УИХ-д оруулж, батлуулсан.

Инфляцийн өсөлтийн чиг хандлагыг илүү сайн илэрхийлэх зорилгоор түүний 2000 онтой харьцуулсан өсөлтийг дараах Зурагт харуулав.

Зураг 1.2. Хэрэглээний үнийн индексээр тооцсон инфляцийн суурь 2000 онтой харьцуулсан өсөлт, хувиар




Эх үүсвэр: ҮСХ, Монгол Улсын Статистикийн эмхтгэл, 2005, 2012, 2013, 2014 оны 12 сарын статистикийн бюллетень

Манай орны ХҮИ-ээр илэрхийлэгдэх инфляцийн түвшин 2014 онд 2000 оныхоос 3.9 дахин нэмэгдсэн байгаа юм. Ялангуяа инфляцийн өсөлтийн муруй 2010 оноос хойш нэлээд цоройсоныг зургаас харж болно.

Сүүлийн жилүүдэд Монгол Улсын эдийн засаг урьд өмнө байгаагүй өндөр өсөлт үзүүлж ирсэн. 2010 онд эдийн засгийн өсөлт 6.4 хувь, 2011 онд 17.5 хувь өссөн бол 2012 онд эдийн засгийн өсөлт 12.3 хувь, 2013 он 11,7 хувь болсон билээ. Харин 2014 оны хувьд ДНБ-ний өсөлт 7,8 хувь болж, өсөлтийн хувь нь буурсан.

Манай оронд эдийн засгийн өсөлт, тэлэлт болон инфляци хоорондоо ихэнхи тохиолдолд уялдаатай өсөж, буурч ирсэнийг доорх зургаас харж болно. Эдийн засгийн уналттай байсан 2009 онд инфляци ердөө 4.2 хувиар нэмэгдсэнийг өмнөх Зураг 1.1. болон доорх Зургаас давхар харж болно.

Зураг 1.3. ДНБ болон ХҮИ-ийн жил бүрийн өөрчлөлтийн хувь




Эх үүсвэр: ҮСХ, Монгол Улсын Статистикийн эмхтгэл, 2005, 2012, 2013, 2014 оны 12 сарын статистикийн бюллетень

Инфляци болон эдийн засгийн өсөлтийн хоорондын хамаарал нь шугаман бус буюу инфляци тодорхой түвшинд хүртэл өсөх нь нийлүүлэлтийг урамшуулдагаараа эдийн засгийн өсөлтийг дэмждэг бол тодорхой түвшний дараагаас тэр нь эдийн засгийн өсөлтөд сөрөг нөлөө үзүүлэг болохыг олон судлаачид нотолдог.

Үүнийг илүү тодорхой судлахын тулд энэхүү 2 үзүүлэлтийн суурь онтой харьцуулсан өсөлтийг доорх Зурагт харуулав.

Зураг 1.4. ДНБ болон ХҮИ-ийн суурь онтой харьцуулсан өсөлт, 2000=1, дахин




Эх үүсвэр: ҮСХ, Монгол Улсын Статистикийн эмхтгэл, 2005, 2012, 2013, 2014 оны 12 сарын статистикийн бюллетень

Зургаас харахад 2006 он хүртэл эдийн засгийн болон инфляцийн өсөлт үндсэндээ ойролцоо байснаа 2007 оноос, ялангуяа 2009 оноос инфляцийн өсөлт эдийн засгийнхаа

өсөлтөөс илэрхий давамгайлсан хурдацтай нэмэгджээ. Ер нь 2006 оноос өмнө инфляцийн өсөлтийг тогтоон барьж чадаж байжээ. Инфляцийн өсөлтийг 2008 оны хямралаас хойш хязгаарлаж чадаагүй байна. Энэ нь эдийн засгийн өсөлт, тэлэлтийг дэмжсэн мөнгөний бодлоготой зарим талаар холбоотой гэж үзэж байна.

Инфляцийн ерөнхий чиг хандлагыг илрүүлэх зорилгоор статистик боловсруулалтын нэг арга болох гулсуулсан дундажийг 13 сараар тооцож Зураг 1.5.-д харуулав.

Зураг 1.5. ХҮИ болон түүний 13 сарын шаталсан дундаж өсөлт, хувиар



Эх үүсвэр:ҮСХ-ны 2006-2013 оны сар бүрийн бюллетень

Инфляцийн олон жилийн ерөнхий чиг хандлагаас (трендээс) харахад 2007 оны дундаас 2008 оны 4 сар хүртэл инфляци ихээхэн өсөлттэй байсан бөгөөд түүнээс хойш инфляцийн түвшин ерөнхийдөө харьцангуй тогтворжиж, өсөлт бууралтын хэлбэлзэл нь багассан байна. Гэхдээ энэ инфляцийн түвшин өсөөгүй гэсэн үг биш, харин огцом хэлбэлзэл нь арай багассан юм.

1.2. Суурь инфляцийн өсөлт

Шилжилтийн эдийн засагтай орнуудын хувьд инфляцийг хэмждэг энгийн арга нь хэрэглээний үнийн индекс (ХҮИ) билээ. ХҮИ нь хэрэглээний сагсанд сонгон авсан бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийн жигнэсэн дундаж хэмжээ юм. Инфляцийн энэхүү хэмжүүр нь мөнгөний болон мөнгөний бус хүчин зүйлээс хамаардаг. Тэгэхлээр инфляцийг хэмжихдээ мөнгөний болон мөнгөний бус хүчин зүйлийг ялгаж зааглах шаардлага гардаг.

Мөнгөний бус хүчин зүйлийн инфляцийн хэмжүүрт үзүүлэх хүчтэй нөлөө нь үнийн өөрчлөлтийн мэдэгдэхүйц тогтворгүй, хувирамтгай байдлыг үүсгэдэг тул инфляци нь үнийн урт хугацааны чиг хандлагын үр дүн юм уу аль эсвэл зөвхөн богино хугацааны өөрчлөлтийн тусгал юм уу гэсэн асуулт урган гардаг. Хэрэв инфляцийн хэмжүүр нь

богино хугацааны өөрчлөлтийг агуулж байвал улс төрчдийн хувьд инфляцийг хяналтандаа байлгах зорилгоо хэрэгжүүлэхэд төвөгтэй болдог.

Суурь инфляци гэж нэрлэгддэг инфляцийн хэмжүүр нь мөнгөний хүчин зүйлээс үүдэлтэй үнийн урт удаан хугацааны өөрчлөлтийг илүү сайн илэрхийлдэг. Суурь инфляцийг ашиглах үндсэн шалтгаан нь үнийн богино хугацааны түр зуурын шинжтэй өөрчлөлтийг үл харгалзан харин эдийн засаг дахь тогтвортой өөрчлөлтийг судлахад оршдог.

Суурь инфляцийн үзэл баримтлал нь харьцангуй шинэ бөгөөд 1980–аад оны эхээр (Eckstein 1981) анх дэвшүүлсэн байдаг. Eckstein нь “Суурь инфляци нь эдийн засгийн урт хугацааны өсөлтийн үеийг харуулдаг бөгөөд энэ үе нь шокоос ангид, эрэлтийн байдал төвийн, энэ утгаараа зах зээл урт хугацааны тэнцвэрт оршиж байдаг.”¹ гэж үзэж байв. Eckstein инфляцийг хэмжих хэмжүүрийг Филлипсийн муруйтай холбож, инфляцийн ирээдүйн төлөв, эдийн засгийн идэвхижлийн бодит болон боломжит дээд түвшингийн хоорондох зааг, нийт нийлүүлэлтийн шок зэргийг холбон тайлбарласан. Тэр эндээс суурь инфляци нь инфляцийн ирээдүйн төлөв байдлыг илэрхийлдэг гэж тогтоосон. 1990–ээд онд олон улс орнуудын төв банкууд инфляцийг онилсон бодлогыг явуулдаг болсон (Haldane 1995; Neumann and von Hagen 2002). Энэ үеэс төв банкууд дээрх бодлогын хүрээнд инфляцийн талаар тавьсан зорилтдоо хүрэхийн тулд суурь инфляцийг хэмжих явдлыг чухалчлан авч үзэх болсон. Энэ бүхэн нь цаашдаа суурь инфляцийн талаарх үзэл баримтлалыг улам анхаарч, хөгжүүлэх, улмаар суурь инфляцийг хэмжих аргуудыг хөгжүүлэхэд түлхэц болжээ.

Суурь инфляци нь үнэ нь тогтворгүй, амархан өөрчлөгддөг нэр төрлийн бараа, үйлчилгээг хэрэглээний үнийн сагснаас хасаж, үлдсэн нэр төрлөөр инфляцийг тооцдог тул улирлын чанартай, эрэлт, нийлүүлэлтээс шалтгаалсан үнийн өсөлтийн нөлөөг арилгасан, үнийн дунд болон урт хугацааны ерөнхий өсөлтийн чиг хандлагыг сайн илэрхийлдэг онцлогтой.

Суурь инфляци нь нийт эдийн засаг дахь дунд болон урт хугацааны үнийн ерөнхий чиг хандлагыг сайн илэрхийлдэг тул улс орнуудын төв банк түүнийг мөнгөний бодлогоо тодорхойлоход өргөн ашигладаг. Суурь инфляци нь нөгөө талаасаа ирээдүйн үнийн өөрчлөлтийг урьдчилан тооцоход өргөн ашиглагддаг.

Ихэнхи улс орнуудын туршлагаас харахад статистикийн байгууллага нь суурь инфляцийг ХҮИ–ээр тооцсон инфляцийн нэмэлт хэмжүүр болгон тооцож, эдийн засаг дахь үнийн ерөнхий түвшнийг хэмжихэд ашиглаж байна. Канад, Чех, Финлянд, Тайланд болон Өмнөд Африкийн бүгд найрамдах улсуудын төв банкууд инфляцийг онилсон бодлого явуулахдаа суурь инфляцийг өргөн ашигладаг байна.

¹ Eckstein (1981), page 8.

Суурь инфляцийг тооцдог олон аргууд байдаг. Одоогоор нийтдээ 3 бүлэг аргыг ихэвчлэн хэрэглэж байна. Эдгээр нь хэрэглээний сагснаас тодорхой нэрийн бараа үйлчилгээг хасаж тооцдог механик арга, статистикийн аргууд болон эконометриксийн аргууд юм.

Суурь инфляцийг заримдаа хэрэглээний бараа, үйлчилгээний сагснаас тогтсон нэр төрлүүдийг байнга хасах замаар, тэр тусмаа тэдгээрийн үнийн өсөлт бага байсан ч хамаагүй хасаж сар бүр тооцож байхад зарим тохиолдолд тухайн сар бүрийн хувьд үнэ нь өндөр өсөлттэй байсан бараа, үйлчилгээний нэр төрлүүдийг сар бүр хасаж тооцдог арга ч байдаг.

Суурь инфляцийг хэрэглээний сагснаас тодорхой нэрийн бараа, үйлчилгээг хасаж тооцдог арга нь дотроо 5 төрөлтэй байна. Үүнд:

1. Хүнсний бараа болон эрчим хүчийг хассан ХҮИ (CPI excluding food and energy)
2. Хамгийн их өсөлттэй болон хамгийн бага бууралттай нэр төрлүүдийг хасах арга (The trimmed mean)
3. ХҮИ-ийн медианаар тооцох арга (The median CPI)
4. Эрчим хүчийг хассан ХҮИ (CPI excluding energy)
5. Найман нэрийн бараа, үйлчилгээг хассан ХҮИ (CPI excluding 8 components)

Суурь инфляцийг хөгжингүй орнууд 1990-ээд оны дунд үеэс эхлэн тооцож иржээ. Зарим орнуудад суурь инфляцийг тооцож байгаа түгээмэл аргуудыг доорх хүснэгтэд харуулав.

Хүснэгт 1.1. Зарим улс орнуудад суурь инфляцийг тооцдог аргууд

Улс орнууд	Албан ёсны үндсэн хэмжигдэхүүн	Төв банкнаас нь хийдэг бусад тооцоо
Канад	Хүнс, эрчим хүч, шууд бус татварыг хассан ХҮИ	-Үнэ нь хамгийн их хэлбэлзсэн 8 нэр төрлийг хассан ХҮИ (16%) -Жигнэсэн медианы арга -Хамгийн их өсөлттэй болон хамгийн бага бууралттай нэр төрлүүдийг хасах арга (15%)
Австраль	Treasury underlying CPI	-Хамгийн их өсөлттэй болон хамгийн бага бууралттай нэр төрлүүдийг хасах арга -Жигнэсэн медианы арга
Шинэ Зеланд	Зээлийн хүүг хассан ХҮИ	-Үнэ нь хамгийн их хэлбэлзсэн нэр төрлүүдийг хассан ХҮИ (30%) -Жигнэсэн медианы арга
Япон	Шинэ хүнсийг хассан ХҮИ	
АНУ	Хүнс, эрчим хүчийг хассан ХҮИ	
Англи	Моргежийн зээлийн хүүг хассан жижиглэнгийн барааны үнийн индекс	-Жигнэсэн медианы арга -Хамгийн их өсөлттэй болон хамгийн бага бууралттай нэр төрлүүдийг хасах

		арга(15%)
ХБНГУ	Шууд бус татварыг хассан ХҮИ	
Тайланд	Шинэ хүнс болон эрчим хүчийг хассан ХҮИ (23%)	-Хамгийн их өсөлттэй болон хамгийн бага бууралттай нэр төрлүүдийг хасах арга(10%)

Эх үүсвэр: <http://www.docstoc.com/docs/68851283/What-is-core-inflation-Flow-of-Funds>

Тайлбар: Тодорхой аргуудын ард хаалтанд харуулсан хувь нь хэрэглээний жинд хасагдсан нэр төрлийн эзлэх хувийг илэрхийлнэ.

Статистикийн аргууд буюу 2 дахь бүлэг аргуудад хамгийн их өсөлттэй болон хамгийн бага бууралттай нэр төрлүүдийг хасах арга, жигнэсэн медианы арга, S.Roger-ийн суурь инфляцийг тооцох статистикаргууд ордог. Эконометрикийн аргуудад бүтцийн вектор авторегрессийн (Structural VAR) арга болон инфляци болон эдийн засгийн бусад үзүүлэлтүүдийн хоорондох статистикийн хамаарлыг илэрхийлсэн регрессийн загварууд ашиглах арга ордог байна.

Манай оронд Монголбанк суурь инфляцийг Улаанбаатар хотын ХҮИ тооцдог сагснаас мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн болон хүнсний ногооны бүлгийнбараа, бүтээгдэхүүнийг хассаны дараа үлдсэн бараа, бүтээгдэхүүнээр тооцдог. Хасагдсан нэр төрөл 37 болдог.

Зарим судлаачид манай орны хувьд суурь инфляцийг хүнсний бараа болон эрчим хүчийг хассан ХҮИ (CPI excluding food and energy)- ээр, хамгийн их өсөлттэй болон хамгийн бага бууралттай нэр төрлүүдийг хасах аргаар (The trimmed mean) болон ХҮИ-ийн медианаар тооцох аргаар(The median CPI) тооцсон судалгааны ажил нийтлүүлжээ.²

Доорх зурагт Монголбанкнаас сар бүр тооцсон суурь инфляцийг ҮСХ-ноос ХҮИ-ээр тооцсон сар бүрийн инфляцийн өөрчлөлттэй харьцуулан харуулав.

Зураг 1.6. Улаанбаатар хотын хэрэглээний үнийн индексээр тооцсон болон суурь инфляцийн сар бүрийн өсөлт, хувиар




²Б.Энх-Амгалан, Б.Батмөнх, “Монгол Улсын хэрэглээний үнийн индексэд хүнсний бүтээгдэхүүний үнийн үзүүлэх нөлөө болон олон улсын туршлага”, АХБ-наас санхүүжүүлсэн судалгааны ажлын тайлан, 2014 он

Эх үүсвэр: Монголбанкны сарын бюллетень, ҮСХ-ны сарын бюллетень

Зургаас харахад хүнсний зарим тогтворгүй үнэтэй нэр төрлийн бүтээгдэхүүнийг ХҮИ тооцдог сагнаас хасаж, үлдсэн нэр төрлөөр нь тооцсон суурь инфляцийн өсөлт сонгосон хугацааны ихэнх саруудад хэрэглээний үнийн сагны бүх нэр төрлөөр тооцсон инфляцийн өсөлтөөс бага байна. Харин жил бүрийн намрын саруудад, тухайлбал, 8 болон 9 саруудад ХҮИ-ээр тооцсон инфляцаас суурь инфляци нь илүү өсөж ирсэн байна. Үүнийг нарийвчлан судлаж үзэхэд оюутны сургалтын төлбөр жил бүрийн намар нэмэгддэгтэй холбоотой байна. ХҮИ-ээр тооцсон инфляцийн улаан шугам мөн жил бүрийн намрын саруудад бага зэрэг нэмэгддэгийг ажиглаж болно. Суурь инфляцийг тооцдог сагнаас хүнсний үнэ тогтворгүй бүтээгдэхүүнийг жинтэй нь хасаж, үлдсэн нэр төрлөөр тооцдог тул өндөр хувийн жинтэй хүнсний барааны жин хасагдсан тул бусад нэр төрлүүдийн жин нэмэгдэж, үүний дотор сургалтын төлбөрийн жин нэмэгдэж, төлбөр нь намартаа өсдөг нь суурь инфляцид илүү хүчтэй нөлөөлдөг байна.

Зураг 1.7. Улаанбаатар хотын хэрэглээний үнийн индексээр тооцсон болон суурь инфляцийн суурь үетэй харьцуулсан өсөлт, хувиар



Эх үүсвэр: Монголбанкны сарын бюллетень, ҮСХ-ны сарын бюллетень

Зураг 1.7 –д харуулсан инфляцийн хоёр төрлийн хэмжүүрийг суурь үе болох 2010 оны 1-р сартай харьцуулсан өсөлтийг харуулав. Суурь инфляцийн өсөлт ХҮИ-ээр тооцсон инфляцийнхаас арай бага байгааг харж болно. Суурь инфляцийг цэвэр мөнгөний хүчин зүйлтэй холбоотой инфляци гэж үзвэл хоёр шугамын хооронд үүссэн зөрүү нь үндсэндээ эрэлт, нийлүүлэлтэй холбоотой хүчин зүйлээс үүдэлтэй инфляци гэж ойлгож болно. Энэ нь Монгол Улсын ХҮИ-ээр тооцсон инфляцид цэвэр мөнгөний хүчин зүйлийн зэрэгцээ мөнгөний бус хүчин зүйл ихээхэн нөлөөтэй байгааг гэрчилж байна.

Төрөөс явуулж байгаа мөнгөний бодлого нь мөнгөний хүчин зүйлд илүү нөлөөтэй байдаг бол мөнгөний бус хүчин зүйлд нөлөө багатай гэж үздэг. Эндээс Монголбанкнаас явуулж байгаа мөнгөний бодлого нь дангаараа инфляцийг баталгаатай тогтоон барих шууд нөлөө багатай гэж үзэж болно. Эндээс инфляцийг тогтворжуулахад мөнгөний бус хүчин зүйлд нөлөөлж чадах Засгийн газрын үүрэг оролцоо чухал гэдэг дүгнэлт гарч байна.

Төрийн мөнгөний бодлогыг Монголбанк хэрэгжүүлэхдээ түгээмэл хэрэглэж ирсэн хэрэгсэл болох бодлогын хүүгээрээ дамжуулан мөнгөний нийлүүлэлтэд нөлөөлөх арга юм. Төв банкны бодлогын хүүг бууруулах нь арилжааны банкнуудын зээлийн хүүд шууд нөлөөлдөг эсэх нь манай орны хувьд нэлээд эргэлзээтэй байдаг. “Бодит байдал дээр мөчлөг дагасан бодлого нь банкуудын системд ажиглагдсаар байгаа бөгөөд мөнгөний бодлогын хүү хэдий өндөр боллоо ч банкуудын нөөц их байгаа тул зээлийн түвшингээ бууруулахгүй эдийн засгийг халааж байна гэх үндэслэл бодитой болж байна” гэж зарим судлаачид үздэг.³

МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн багш нарын хийсэн регрессийн шинжилгээний дүнгээр мөнгөний бодлогын хүүг 1 хувиар нэмэгдүүлэхэд хоёр сарын дараагаас хүнсний бараа бүтээгдэхүүний инфляцийг 0.0013 пунктээр бууруулж байгаа дүн гарсан. Энэ нь мөнгөний бодлогын хэрэгсэл тун бага нөлөөтэйг харуулсан.⁴Төв банкны үнэт цаасны хүү (ТБҮЦ) бусаддаа дамжсан нөлөөтэй байна уу гэдгийг сонирхож, нөлөөлөл байгаа эсэхийг Монголбанкны судлаачид 2001 онд судалсан бөгөөд ТБҮЦ нь банкнуудын зээлийн хүүд маш сул нөлөөлдөг болохыг илрүүлсэн ажээ.

Мөнгөний бус хүчин зүйлд эрэлтийн болон нийлүүлэлтийн шокоос үүдэлтэй хүчин зүйлүүд ордог. Тухайлбал, төсвийн зардлын богино хугацааны хэт өсөлт нь эрэлтийн инфляцийг бий болгодог бөгөөд энэ үед мөнгөний бодлогоор нөлөөлөх боломж муутай. Иймээс Монголбанк ба Засгийн газар нь мөнгөний болон төсвийн бодлогоо нягт уялдуулж байх шаардлагатай байдаг. Нөгөө талаасаа нийлүүлэлтийн шинжтэй инфляцид мөнгөний бодлогын арга хэрэгслүүд сайн үйлчилдэггүй тул энэ нөхцөлд мөнгөний бодлого үнэн хэрэгтээ нөлөөгүй байдаг. Нийлүүлэлтийн шинжтэй шокийг Засгийн газар голлон зохицуулах боломжтой билээ.

1.3. Манай орны инфляцийн өсөлтийг бусад улс орнуудтай зэрэгцүүлсэн байдал

Манай орны инфляцийн өсөлтийг шилжилтийн эдийн засагтай бусад орнуудтай харьцуулж доорх хүснэгтэд харуулав.

³Ч.Энхбаяр, Г. Пүрэвсүрэн “ Монголын санхүүгийн системийн өнөөгийн байдал, санхүүгийн систем дэх гадаадын шууд хөрөнгө оруулалтыг шингээх чадвар”,МУИС, “ЭЗС-ийн”ЭДИЙН ЗАСАГ:онол, практик” сэтгүүл, 2011№369

⁴Б.Энх-Амгалан, Б.Батмөнх, “Монгол Улсын хэрэглээний үнийн индексэд хүнсний бүтээгдэхүүний үнийн үзүүлэх нөлөө болон олон улсын туршлага”, АХБ-наас санхүүжүүлсэн судалгааны ажлын тайлан, 2014 он

Хүснэгт-1.2. Шилжилтийн эдийн засагтай орнуудын ХҮИ-ээр тооцсон инфляцийн өсөлт,хувь, 2000=100

	2003	2005	2007	2008	2009	2010	2011	2012	2013
Монгол	114.9	139.6	174.7	213.3	222.3	251.1	273.5	311.8	350.7
Хятад	108.3	114.5	121.8	129	128.1	131.95	139.1	142.6	146.1
ОХУ	159.9	199.9	239.1	272.8	304.7	325.7	353.1	376.0	400.4
Армен	118.2	135.2	163.2	177.7	183.8	198.8	214.1	219.7	232.5
Азербайжан	106.6	124.8	157.8	190.96	193.2	204.3	220.4	222.8	234.8
Беларус	294.8	358.6	415.9	477.5	539.1	580.6	889.5	1416.1	1675.2
Болгар	116.1	129.6	150.8	169.3	174	178.2	185.7	191.2	193.0
Чех	106.7	111.6	117.8	125.3	126.6	128.3	130.8	135.1	137.0
Эстони	110.9	118.9	132.4	146.1	146.0	150.4	5.0	3.9	168.6
Унгар	120.3	133.1	149.2	158.3	164.9	173.0	179.9	190.2	193.4
Казакстан	122.0	140.4	168.9	197.9	212.4	227.5	246.4	258.9	273.9
Киргиз	112.4	122.2	142.2	177.0	189.2	204.4	238.1	244.5	260.7
Лаос	137.7	163.1	182.1	195.9	195.9	207.6	223.4	233.0	247.9
Латви	107.6	121.9	142.9	165.0	170.7	168.9	176.3	180.3	180.3
Молдав	129.1	162.7	206.3	232.7	232.5	249.7	268.7	281.0	294.0
Польш	108.4	114.6	118.7	123.8	128.5	131.9	137.5	142.4	143.9
Румын	190.0	231.7	258.9	279.0	294.7	312.7	330.8	351.6	366.4
Словак	120.4	132.9	142.8	149.3	151.7	153.2	159.2	164.9	167.3
Таджикстан	180.9	207.5	258.1	311.0	330.9	352.1	395.7	418.7	439.6
Украйн	144.7	179.2	220.5	276.1	320.0	350.1	378.1	380.4	379.3
Вьетнам	106.7	124.6	144.9	178.4	191.0	208.0	246.9	269.4	287.2

Эх үүсвэр:World bank,World Development Indicators-2013,

2000 онтой харьцуусан энэхүү суурь өсөлтийг сүүлийн 13 жилийн жил бүрийн өсөлтийн хэлхээ индексийг ашиглан тооцлоо. Шилжилтийн эдийн засагтай эдгээр 21 орон дотор 2000-2013 оны хооронд инфляци хамгийн өндөр хурдацтай нэмэгдсэн орны тоонд инфляцийн түвшин нь 16.7 дахин өссөн Беларус, 4,4 дахин өссөн Таджикстан, 4,0 дахин нэмэгдсэн ОХУ, 3,8 дахин өссөн Украин, 3,7 дахин өссөн Румын, 3,5 дахин өссөн Монгол Улс орж байна. Гэтэл дээрх 13 жилийн хугацаанд Чех, Хятад зэрэг оронд инфляцийн өсөлт ердөө 37-46,1 хувь байжээ. Сүүлийн 13 жилийн инфляцийн өсөлтийн хэмжээгээрээ шилжилтийн эдийн засагтай орнууд дотроо манай улс эхнээсээ 7–д орсон байна.

Шилжилтийн эдийн засагтай орнуудтай харьцуулахад хөгжингүй орнуудын инфляцийн өсөлт харьцангуй бага байсаныг доорх хүснэгтээс харж болно.

Хүснэгт-1.3.Хөгжингүй орнуудын ХҮИ-ээр тооцсон инфляцийн өсөлт, 2000=100

	2003	2005	2007	2008	2009	2010	2011	2012	2013
АНУ	103.3	108.2	114.9	119.3	118.8	120.7	124.6	126.6	128.5

Япон	98.2	97	97.3	98.7	97.4	96.7	96.4	96.3	96.6
ХБНГУ	104.2	107.3	111.5	114.4	114.8	116	118.7	121.1	122.8
Франц	106	109.9	114.4	115.6	116	116.2	119.9	122.5	124.3
Итали	108.1	112.6	117.1	121	121.9	123.8	127.2	131.1	132.6
Англи	104.7	108.5	114.1	117.6	120.3	124.3	129.9	133.5	137
Канад	107.7	112	117	119.8	120.2	122.3	125.9	127.8	128.9

Эх үүсвэр: <http://www.inflation.eu/inflation rates/cpi-inflation.aspx>


2000-2013 оны хооронд хөгжингүй орнуудын инфляци хамгийн өндөр нь Ангид 37 хувь байсан бол Японд бүр 3.4 хувиар буурсан байна.

Дэлхийд инфляцийн өсөлтөөрөө хамгийн толгой цохиж байгаа орнууд ч бас байна. Тухайлбал, Латин Америкийн Венесуэл улс сүүлийн 4 жилд инфляцийн хамгийн өндөр өсөлттэйорноор тодорчээ. 2009-2013 онд жилийн инфляцийн дундаж өсөлт нь 21,1-40 хувь байсныг Дэлхийн банкны цахим хуудсанд (www.data.world bank) харуулжээ.

1.4.Дэлхийн болон Монголын зах зээл дэх хүнсний барааны үнийн өөрчлөлтийн харьцуулалт

Энэ хэсэгт Монголын хүнсний бараа бүтээгдэхүүний үнийн өөрчлөлт, үүний дотор голлох нөлөөтэй үхрийн мах, гурил, цагаан будаа гэсэн гурван барааны үнийн өөрчлөлтийг дэлхийн зах зээл дээрх үнийн өөрчлөлттэй харьцуулан судалж үзэв.

Зураг 1.8. Дэлхийн болон Монголын зах зээл дэх хүнсний бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтийн хувь, 2005=100



Эх үүсвэр: Үндэсний Статистикийн Хороо, ОУВС-н тоо мэдээ (WEO) судлаачийн тооцоо

Зураг 1.8-аас харахад дэлхийн хүнсний бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс Монгол дахь хүнсний бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт илүү өндөр хурдацтай нэмэгдэж ирсэн байна. 2005 оны 12 сарыг суурь болгосон дүнгээс харахад 2013 оны 3 сар гэхэд Монгол

дахь хүнсний бараа бүтээгдэхүүний үнэ 3 дахин өссөн бол дэлхийн хэмжээнд энэ үзүүлэлт 1.8 дахин өссөн дүнтэй гарчээ.


Сар бүрийн хүнсний бараа бүтээгдэхүүний үнийн дундаж өөрчлөлт Монголд 1.24 хувь, байхад дэлхийд энэ үзүүлэлт 0.65 хувь байна. Хөрш зэргэлдээ ОХУ, БНХАУ болон Төвийн Азийн ижил нөхцөл бүхий Казакстан, Киргизстантай харьцуулсан үр дүнгээс харахад ч Монголын хүнсний бараа бүтээгдэхүүний үнийн дундаж өөрчлөлт өндөр байсан.

Хүнсний бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт өндөр гарахад гол нөлөө үзүүлдэг махыг (нийт ХҮИ-д мах махан бүтээгдэхүүний бүлэг дангаараа 16.5 хувийг эзэлдэг) төлөөлүүлэн үхрийн мах, мөн гурил будааны (нийт ХҮИ-д талх, гурил, будааны бүлэг дангаараа 10 хувийг эзэлдэг) үнийн өөрчлөлтийг дэлхийн зах зээлийн үнэтэй харьцуулан авч үзье.

1.4.1. Үхрийн махны үнийн өөрчлөлт

Монголчууд бусад улс орны хүн амыг бодвол цаг уурын онцлог, амьжиргааны нөхцөл байдлаас шалтгаалан хоол хүнсэндээ мах, махан бүтээгдэхүүнийг түлхүү хэрэглэдэг. Тиймээс махны үнийн өөрчлөлт нь ХҮИ-г ихээхэн хэлбэлзүүлэх гол шалтгаан болдог. Монгол дахь үхрийн махны үнийн өсөлтийг харвал улирлын нөлөөтэй зун, намрын улиралд махны үнэ буурч, өвөл өсч байна (Зураг 1.9). Үхрийн махны үнийн өсөлтөд гурван онцлог хугацаа байна. Нэгдүгээрт дэлхийн эдийн засгийн хямрал эхлэх үе буюу 2008 оны хавар орно. Энэ хугацаанд дэлхийн төдийгүй Монголын хүнсний барааны үнэ огцом нэмэгдэж байсан байна.

Зураг 1.9. Дэлхийн болон Монголын зах зээл дэх үхрийн махны үнийн өсөлтийн хувь, 2005=100



Эх үүсвэр: Үндэсний Статистикийн Хороо, ОУВС-н тоо мэдээ (WEO) судлаачийн тооцоо

Хоёрдугаар үе нь дэлхийн эдийн засгийн хямрал үргэлжилж инфляцийн түвшин харьцангуй бага байсан ч Монголд 2009-2010 онд тохиолдсон байгалийн гамшиг болох зудны нөлөөгөөр махны үнэ огцом өссөн байна. Энэ нь Монголын хүнсний бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтөд хүчтэй нөлөөлсөн.


Гурав дахь үе нь эдийн засгийн өндөр өсөлт, нийгмийн халамжийн хэт хавтгайруулсан бодлогын үр дүнд 2011 оны 12 сараас махны үнийн өсөлт огцом нэмэгдсэн бөгөөд 2012 оны 6 сараас үнэ бага зэрэг буурсан боловч 2012 оны 11 сараас буцаад үнийн өсөлт явагдаж байна. Энэ хугацаанд өмнөх махны үнийн өсөлттэй харьцуулахад хамаагүй өндөр байгаа нь харагдаж байна.

2005 оны 12 сараас 2013 оны 3 сар хүртэлх үхрийн махны үнэ нийтдээ 3.7 дахин өссөн (хэдийгээр энд харуулаагүй боловч хонины махны үнэ энэ хугацаанд 4 дахин өссөн) байгаа нь дэлхийн үхрийн махны үнэтэй харьцуулахад ихээхэн өндөр байгаа юм.

1.4.2. Гурилын үнийн өөрчлөлт

Гурилын үнийн өөрчлөлтийг дэлхийн гурилын үнийн өөрчлөлттэй харьцуулбал ойролцоо түвшинд байна (Зураг1.10). Үнийн хэлбэлзлийн хувьд Монголын гурилын үнийн хэлбэлзэл дэлхийн гурилын үнийн хэлбэлзлээс бага байгаа бөгөөд 2008 оны 4 сараас хойш үнийн томоохон өөрчлөлт гараагүй нь Засгийн газрын Атарын 3-р аяныг амжилттай зохион байгуулсан, түүнчлэн гуоилын үнийг Засгийн газраас хянаж, тариалан эрхлэгчид болон гурил үйлдвэрлэгчидтэй буудайны үнийг тохиролцож ирсэнтэй холбоотой гэж үзэж болох юм.

Зураг 1.10. Дэлхийн болон Монголын зах зээл дэх гурилын үнийн өсөлтийн хувь, 2005=100



Эх үүсвэр: Үндэсний Статистикийн Хороо, ОУВС-н тоо мэдээ (WEO) судлаачийн тооцоо


Харин дэлхийн гурилын үнийн өөрчлөлт дэлхийн эдийн засгийн хямрал хүртэлх хугацаа, дэлхийн эдийн засгийн хямрал явагдах хугацаа, хямралын дараах хугацаанаас хамааран ихээхэн хэлбэлзэлтэй байгаа боловч сүүлийн 2-3 жилийн хугацаанд үнийн өөрчлөлт харьцангуй тогтворжсон үр дүн харагдаж байна.

1.3.3.Цагаан будааны үнийн өөрчлөлт

Цагаан будааны үнийн өөрчлөлт нь дотоодод цагаан будааг тариалдаггүйтэй холбоотойгоор гадаад зах зээлээс шуудхамааралтай байдаг.Өөрөөр хэлбэл гадаад талаасаа дэлхийн зах зээл дээрх будааны үнийн өөрчлөлт, дотоод талаасаа валютын ханшны өөрчлөлт, шатахууны үнэ буюу тээврийн зардал,эдийн засгийн өсөлт зэргээс хамаарна гэсэн үг.

Гурил, цагаан будааны үнийн өөрчлөлт 2008 он хүртэл дэлхийн зах зээл дээр огцом өсөлттэй боловч энэ нөлөө Монголын хувьд харьцангуй бага байна. Гэхдээ цагаан будааны хувьд 2010 оны 1-р сараас дэлхийн цагаан будааны үнийн өөрчлөлттэй урвуугаар явагдаж Монголд цагаан будааны үнэ өсөж байсан байна.

Зураг 1.11. Дэлхийн болон Монголын зах зээл дэх цагаан будааны үнийн өсөлтийн хувь, 2005=100



Эх үүсвэр: Үндэсний Статистикийн Хороо, ОУВС-н тоо мэдээ (WEO) судлаачийн тооцоо

Энэхүү өсөлт 2010 оны 9 сараас бага зэргийн буурч харьцангуй тогтвортой болсон ч дэлхийн зах зээл дээрх будааны үнийн өсөлтөөс Монгол дахь будааны үнийн өсөлт өндөр хэвээр гарчээ.

Бараа бүтээгдэхүүний үнийн сарын дундаж өөрчлөлтөөс харвал дэлхийн зах зээлийн үнийн өөрчлөлтөөс хамгийн их зөрүүтэй (ойролцоогоор 3.1 дахин их) байгаа нь үхрийн мах болж байна. Хэлбэлзлийн хувьд ч гэсэн бусад үзүүлэлттэй харьцуулахад дэлхийн үхрийн махны үнийн хэлбэлзлээс Монгол дахь үхрийн махны үнийн хэлбэлзэл маш өндөр байна. Харин гурилын хувьд хэлбэлзлийн үзүүлэлт харьцангуй бага байгаа бол цагаан будааны хувьд дэлхийн зах зээлийн үнийн хэлбэлзэлтэй ойролцоо түвшинтэй байна.

Бүлэг-2. Инфляцид үзүүлсэн гол хүчин зүйлийн шинжилгээ, үүнээс валютын ханшны инфляцид үзүүлсэн нөлөөлөл


2.1. Инфляцид нөлөөлөгч голлох хүчин зүйлс

Инфляцийн өсөлтөнд нөлөөлдөг хүчин зүйлс олон байдгийн дотор тухайн улс орны онцлог нөхцөл байдлаас үүдэлтэй хүчин зүйлс ч байдаг. Нөлөөлөгч хүчин зүйлсийг бүхэлд нь мөнгөний гаралтай болон мөнгөний бус хүчин зүйлс гэж бүхэлд нь 2 ангилж болно. Онолын хувьд инфляци бол мөнгөний зах зээл дээр голлон үүсдэг гэж үздэг бөгөөд мөнгөний массыг бараа, таваараар хангаж чадаагүйгээс болж инфляци ихэвчлэн үүсдэг гэж үздэг.

Мөнгөний нийлүүлэлт. Онолын хувьд инфляцид ихээхэн нөлөөтэй байх ёстой мөнгөний нийлүүлэлтийн үзүүлэлт болох

M2болон ХҮИ-ээр илэрхийлсэн инфляцийн өсөлтийг доорх зурагт харуулав.


Зураг 2.1. Мөнгөний нийлүүлэлт (M2) болон ХҮИ-ийн жил бүрийн өсөлтийн хувь



Эх үүсвэр: ҮСХ, Монгол Улсын Статистикийн эмхтгэл, 2005, 2012, 2013,

Зургаас тухайн жилийн мөнгөний нийлүүлэлтийн өсөлттөр дороо инфляцийн түвшинд нөлөөлдөггүй, тодорхой хугацааны дараа нөлөөлдөгбайна.

Зураг 2.2. Нэгдсэн төсвийн нийт зардал, мөнгө M1 болон M2, ХҮИ-ийн суурь онтой харьцуулсан өсөлт, 2000=1, дахинаар



Эх үүсвэр: ҮСХ, Монгол Улсын Статистикийн эмхтгэл, 2005, 2012, 2013, 2014 оны 12 сарын статистикийн бюллетень

Мөнгөний нийлүүлэлт М1 2000-2014 оны хооронд 13.8 дахин, М2 41 дахин, нэгдсэн төсвийн зарлага 16 дахин нэмэгдсэн болон хугацаандинфляцийн түвшин ердөө 3.9 дахин өссөн ажээ. Мөнгөний нийлүүлэлт болон нэгдсэн төсвийн зарлага ХҮИ-тэй харьцуулахад өндөр хурдацтай нэмэгджээ. Ялангуяа 2009 оноос хойшхи сүүлийн 5 жилд мөнгөний нийлүүлэлт болон төсвийн зарлага ихээхэн нэмэгдсэн нь улс төрийн хүчнүүд хүн амд сонгуулийн амлалтын дагуу бэлэн мөнгө ихээр тараасантай зарим талаар холбоотой.

Мөнгөний өсөлт болон инфляцийн хамаарлын талаар Монголбанкны судлаачид хэд хэдэн судалгааны ажил хийсэн байдаг. Монголбанкны мөнгөний бодлого, судалгааны газрын эдийн засагч Д.Ган-Очир⁵ “М1 мөнгөний өсөлт урт болон богино хугацаанд инфляцид хүчтэй нөлөөлж байна. ХҮИ-д үзүүлэх М1 мөнгөний урт хугацааны мэдрэмж бодит ДНБ-ий мэдрэмжээс 2 дахин өндөр байна. М1 мөнгө 10 хувиар өсөх нь хэрэглээний үнийг 6-7 сарын дараа 0.6 хувиар, урт хугацаанд 10 хувиар өсгөхөөр байна” гэсэн дүгнэлт хийжээ. Мөн Монголбанкны мөнгөний бодлого, судалгааны газрын эдийн засагч Л.Даваажаргал (2005)⁶ 1998-2004 оны сар бүрийн өгөгдөлд үндэслэн М1 мөнгөнд гарах өөрчлөлт урт хугацаанд инфляцид нөлөөтэй буюу М1 мөнгө 10 хувиар өсөхөд инфляци 5 хувиар өсөх боломжтой гэсэн дүгнэлтэд хүрчээ.

Монголбанкны дээр нэр дурьдсан эдийн засагч Д.Ган-Очир (2008)⁷ манай орны хувьд мөнгө урт хугацаанд нейтраль буюу бодит үзүүлэлтүүдэд (бодит ДНБ, бодит хүү, бодит цалин г.м.) нөлөөлдөггүй, харин нэрлэсэн үнэ, цалин, хүү, ханшид нөлөөлж байгааг эмперик судалгаагаар нотолжээ. Судлаач энэхүү судалгаандаа мөнгөний нийлүүлэлтийн хурдацтай өсөлт нь урт хугацаанд үнийн өсөлт, нэрлэсэн цалингийн өсөлт болон зээлийн нэрлэсэн хүүний бууралтанд нөлөөлж байгааг тогтоожээ. Эндээс Монголбанк мөнгөний нийлүүлэлтийг аль болох бага байлгаж чадвал урт хугацаанд инфляцийн өсөлтийн хурд харьцангуй бага байх нь тодорхой байна.

Мөнгөний нийлүүлэлтийн хурдацтай өсөлт болон төсвийн зардлын 2010 оноос хойшхи огцом өсөлт нь ХҮИ ойрын жилүүдэд цаашдаа ч өсөх урьдчилсан нөхцөл нь бүрдсэн гэж үзэж болохоор байна.

Төсвийн алдагдал. Инфляцид нөлөөлдөг өөр нэг гол хүчин зүйл нь төсвийн алдагдал юм. Төсвийн зардлын өсөлт нь цалингийн өсөлт болон бараа, үйлчилгээний худалдан авалтын эрэлтийг нэмэгдүүлж, улмаар ХҮИ өсөх нөхцөлийг бий болгодог. Судлаачид аж ахуйн нэгжүүдийн дундаж цалингийн өсөлт бусад хүчин зүйлтэй харьцуулбал инфляцид хамгийн өндөр нөлөө үзүүлж байгааг тогтоожээ. 2006 оны 2 сараас 2013 оны 3 сарын

⁵ Д.Ган-Очир, Монголын эдийн засаг дахь мөнгөний өсөлт болон инфляцийн хамаарал, 2009

⁶ Л.Даваажаргал, Мөнгөний өсөлт ба инфляцийн хоорондох хамаарал, 2005


⁷ Д.Ган-Очир, Монголын эдийн засагт мөнгө урт хугацаанд нейтраль уу?, 2008

хоорондох өгөгдлөөр хийсэн регрессийн шинжилгээний дүнгээр дундаж цалингийн зардал 1 хувиар өсөхөд хүнсний бараа бүтээгдэхүүний инфляци 0.7 пунктээр нэмэгдэж байгааг тогтоожээ.⁸

Ер нь сүүлийн 3 жилд нэгдсэн төсвийн тэнцэл байнга алдагдалтай гарсны дээр нэгдсэн төсвөөс гадуурх эх үүсвэрээс, тухайлбал, Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн Засгийн газрын зардлуудыг нэмбэл энэхүү алдагдал бүр ч их нэмэгдэхээр байгаа юм. Төсвийн ихээхэн хэмжээний алдагдал нь инфляцийг хөөрөгдсөөр ирсэнийг Монгол дахь Дэлхийн банкны суурин төлөөлөгчийн газраас анхааруулж, түүнийг багасгахыг зөвлөсөөр ирсэн билээ.

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцэл 2010 онд 41,8 тэрбум төгрөгийн ашигтай гарч байсан бол 2011 онд 769,8 тэрбумын, 2012 онд 1 их наяд 130 тэрбумын, 2013 онд 297,3 тэрбумын, 2014 онд 808 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсаныг доорх зургаас харж болно.

Зураг 2.3. Улсын нэгдсэн төсвийн 2010-2014 оны орлого, зарлага, тэнцэл, тэрбум төгрөг



Эх үүсвэр: ҮСХ, Монгол Улсын Статистикийн эмхтгэл, 2005, 2012, 2013, 2014 оны 12 сарын статистикийн бюллетень

Чингис бондын санхүүжилт нь эдийн засаг дахь мөнгөний урсгалыг мэдэгдэхүйц нэмэгдүүлсэний зэрэгцээ Засгийн газар үнэт цаас гаргаж, борлуулсан орлогоороо

⁸Б.Энх-Амгалан, Б.Батмөнх, “Монгол Улсын хэрэглээний үнийн индексэд хүнсний бүтээгдэхүүний үнийн үзүүлэх нөлөө болон олон улсын туршлага”, АХБ-наас санхүүжүүлсэн судалгааны ажлын тайлан, 2014 он

томоохон төсөл, хөтөлбөр, хэрэгжүүлж ирсэн нь мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлж, улмаар инфляцийг хөөрөгдөх бас нэг дотоод шалтгаан болж ирсэн.

Дотоод бондын зах зээлд сүүлийн гурван жилийн хугацаанд дараах үнэт цаасыгарилжсан байна. Үүнд:Зоос банкинд бүтцийн өөрчлөлт хийж, тус банкны харилцагч, хадгаламж эзэмшигчдийн хөрөнгийг эрсдэлээс сэргийлэх зорилгоор 100.0 тэрбум төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий Засгийн газрын үнэт цаасыг арилжсан бөгөөд 2012 оны эцсийн байдлаар хуваарийн дагуу 40.0 тэрбум төгрөгийн үнэт цаас төлөгдөж, үлдэгдэл нь60.0 тэрбум төгрөг байв.

Төрийн албан хаагчид, иргэдийг орон сууцаар хангахад урт хугацаат зээлийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор 2010 онд 80.0 тэрбум, 2011 онд 72.0 тэрбум, нийт 152.0 тэрбум төгрөгийн Засгийн газрын үнэт цаас гаргаж Монголбанк, Нийгмийн даатгалын ерөнхий газар болон Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан 1-7 жилийн хугацаатай арилжсан. Энэхүү үнэт цаасыг арилжаалж бүрдүүлсэн эх үүсвэрийг Орон сууцны санхүүжилтийн корпорациар дамжуулан зээлдүүлэх гэрээний үндсэн дээр зээлдүүлж, төрийн албан хаагчдын зээлийн хүсэлтийг үндэслэн шийдвэрлэсэн байна.

Ноос, ноолуур, жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зорилгоор 2011 онд 286.3 тэрбум, 2012 онд 13.7 тэрбум төгрөгийн, нийт 300.0 тэрбум төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий Засгийн газрын үнэт цаасыг 1-5 жилийн хугацаатай гарган арилжаалж, ноос, ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэгч үндэсний үйлдвэрийг дэмжихэд хөнгөлөлттэй нөхцөлтэй зээл олгох, жижиг, дунд үйлдвэрийн сангийн хөрөнгийг нэмэгдүүлэх, хонины болон тэмээний ноос бэлтгэж, үндэсний үйлдвэрт тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий иргэдэд урамшуулал олгох зорилгоор зарцуулсан бөгөөд 2012 оны эцсийн байдлаар нийт 103.0 тэрбум төгрөгийн үндсэн төлбөр хийгдэж, үлдэгдэл нь 197.0 тэрбум төгрөг болсон.

Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор 2010, 2011 онуудад үнэт цаас гаргаагүй бөгөөд 2012 онд 554.9 тэрбум төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий Засгийн газрын үнэт цаас гаргаж, улсын төсвийн улирлын чанартай орлого, зарлагын зөрүүг санхүүжүүлэхэд зарцуулсан болно. 2012 ондоо нийт 194.1 тэрбум төгрөгийн буцаан төлбөрийг төлж, 2012 оны эцэст 368.0 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байв.

Хүний хөгжил сангийн төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор 2012 оны санхүүгийн жилд нийт 313.1 тэрбум төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий Засгийн газрын үнэт цаас гарган арилжаалж зориулалтын дагуу зарцуулсан ба тус үнэт цаасны эхний үндсэн төлбөр 2013 оны сүүлээр хийгдэх хуваарьтай байсан.⁹

Дараагийн хэсэгт бид манай орны онцлог нөхцөл байдлаас үүдэлтэй инфляцид нөлөөлсөн зарим хүчин зүйлсийг авч үзэв.


⁹Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилтийн тухай үндэсний 5 дахь илтгэл, 2013 он

2.2. Хүнсний бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт болон түүний улирлын чанартай хэлбэлзлийн инфляцид үзүүлсэн нөлөө

ХҮИ-ийн сагсанд авсан бараа, бүтээгдэхүүний дотор хүнсний бараа, бүтээгдэхүүний эзлэх хувь 2010 оноос өмнө 41 хувь эзэлдэг байснаа 2010 онд шинэчилсэн сагсаар 30 хувь болж буурсан боловч хүн амын хэрэглээний бараа, үйлчилгээний нийт сагсанд хүнсний бараа, бүтээгдэхүүн харьцангуй өндөр хувийн жин эзэлдэг нь инфляцийн тооцоонд ихээхэн нөлөөтэй байдаг. Энэ бол хүнсний бараа, бүтээгдэхүүний үнэ инфляцид нөлөөлөх зөвхөн нэг шалтгаан нь юм. Нөгөө талаасаа хөдөө аж ахуйн гаралтай хүнсний бараа, бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь улирлын шинжтэй, үүнээсээ үүдээс түүний нийлүүлэлт нь мөн улирлын давтамжтай байдаг нь түүний үнэ тогтворгүй өөрчлөгдөхөд нөлөөлдөг.

1995-2014 оны хоорондох 19 жилийн хэрэглээний үнээр тооцсон инфляцийн болон хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлтийг доорх зурагт харуулав.

Зураг 2.4. ХҮИ болон хүнсний бүтээгдэхүүний үнийн жил бүрийн өөрчлөлт, 1995-2014 он, хувиар




Эх үүсвэр: ҮСХ, Монгол Улсын Статистикийн эмхтгэлүүд, 1997, 2000, 2005, 2008, 2012, 2013, 2014 оны статистикийн бюллетень

Зургаас харахад 1997-2002 оны хооронд хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлт инфляцийн өсөлтөөс үндсэндээ бага байсан бол 2003-2005, 2007-2008, 2011, 2012 онуудад эсрэгээрээ хүнсний үнийн өсөлт инфляцийн өсөлтөөс давсан байна. 2008 онд импортын барааны үнэ өссөний зэрэгцээ төсвийн ажилтнуудын цалин хөлс болон төсвийн зарлага нэмэгдсэний улмаас инфляцийн түвшин 22.1 хувьд хүрч, төгрөгийн ханш унасан билээ.

Инфляци болон хүнсний бүтээгдэхүүний үнийн урт хугацааны өөрчлөлтийг суурь онтой харьцуулан дараах зурагт харуулав.

Зураг 2.5. ХҮИ болон хүнсний бүтээгдэхүүний үнийн суурь онтой харьцуулсан өсөлт, дахин, 1990=1



Эх үүсвэр: ҮСХ, Монгол Улсын Статистикийн эмхтгэлүүд, 1997, 2000, 2005, 2008, 2012, 2013, 2014 оны статистикийн бюллетень


Зургаас харахад 2004 оноос өмнө хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлт инфляцийн өсөлттэй ойролцоо байсан бол 2004 оноос хойш хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлт инфляцийн өсөлтөөс ихээхэн өндөр хурдацтай нэмэгджээ. ХҮИ нь 1990-2014 оны хоорондох 24 жилд 397,1 дахин өссөн бол хүнсний бүтээгдэхүүний үнэ 510 дахин нэмэгджээ. Хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлтсүүлийн жилүүдэд инфляцийг хөөрөгдөх гол дарамт болсоор иржээ.

Эндээс бид ямар дүгнэлт хийж болох вэ гэвэл сүүлийн 10-аад жилд Монгол Улсад инфляцийн өсөлтийг тодорхойлдог гол хүчин зүйл нь хүнсний бараа, бүтээгдэхүүний үнэ гэдэг нь тодорхой харагдаж байна. Энэ байдал ялангуяа 2008 оноос хойш бүр илт болсон нь зураг дээрх 2 муруй улам холдож, хүнсний бараа, бүтээгдэхүүний үнэ илүү хурдацтай нэмэгдэж ирснээс харагдаж байна. Энэ нь нөгөө талаасаа сүүлийн 10-аад жилд хүнсний бараа, бүтээгдэхүүний үнийг Засгийн газар хяналтандаа байлгаж, түүний хэт өндөр өсөлтөөс сэргийлж чадаагүйг харуулав. Энэ байдлаас харахад юуны өмнө хүнсний бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлтийг хянаж чадвал инфляцийг бүхэлд нь хянах боломжтой байсныг харуулж байна.

Сүүлийн 9 жилийн ХҮИ-ийн сар бүрийн өөрчлөлтийг авч үзэхэд манай орны ХҮИ буюу инфляци ихээхэн тогтворгүй, өсөлт, бууралт ихтэй, үүний дотор хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлт бусад бараа, бүтээгдэхүүнийхээс илүү тогтворгүй өсөлт,

бууралт илүү ихтэй байсан нь Зураг 2,6-аас харагдаж байна. Нөгөө талаараа хүнсний бүтээгдэхүүний үнийн өөрчлөлтийг ХҮИ дагаж өөрчлөгддөг нь тодорхой харагдаж байна.

Зураг 2.6. Хэрэглээний үнийн болон хүнсний бүтээгдэхүүний үнийн сар бүрийн өөрчлөлт, хувиар, 2006 оны 1 сараас 2014 оны 12 сар




Эх үүсвэр: ҮСХ-ны 2006-2014 оны сар бүрийн бюллетень

Зургаас харахад хүнсний бүтээгдэхүүний үнийн өөрчлөлт улирлын шинжтэй байна. Энэ нь хүнсний бүтээгдэхүүний улирлын чанартай нийлүүлэлтээс хамааралтай үнэ өсч, буурч байгааг ажиглаж болно. Жил бүрийн 12 сараас хэрэглээний бараа, үйлчилгээний дундаж үнэ өсч, улмаар дараа оны 5 дугаарсар хүртэл ихэвчлэн өсөөд дараа нь 6,7,8 дугаар саруудад буурдаг ерөнхийзүй тогтол ажиглагдаж байна. Ялангуяа энэ байдал хүнсний бүтээгдэхүүн дээр бүр ч тодорхой харагдаж байна.

Инфляцийн болон хүнсний бүтээгдэхүүний үнийн улирлын хэлбэлзлийн шинж төрхийг улирлын индексээр илэрхийлж, Зураг 2.7-д харуулав.

Зураг 2.7. Хэрэглээний үнийн болон хүнсний бүтээгдэхүүний үнийн улирлын индекс



Эх үүсвэр: ҮСХ-ны 2006-2014 оны сар бүрийн бюллетень

Зураг 2.7.-д харуулсан сүүлийн 9 жилийн инфляцийн саруудын өсөлт, бууралтын төлөв байдлаас харахад жилийн эхний улиралд инфляци ерөнхийдөө бага зэрэг нэмэгдээд 9,10 сард буурч, 11,12 сард эргээд өсдөг давтамжтай байна.Эндээс мөн хүнсний бүтээгдэхүүний үнийн улирлын хэлбэлзэл ХҮИ-ээс ч илүүбайгаа нь харагдаж байна. Олон жилийн дунжаар хүнсний бүтээгдэхүүний үнэжил бүрийн 8 болон 9 сард буурдаг, 10 сараас 1-р сар хүртэл өсдөг,1-5 сарын хооронд үндсэндээ тогтвортой байгаад5-р сараас буурч ирдэг зүй тогтолтой ньхарагдаж байна.

Манай оронд хүнсний бүтээгдэхүүний үнэ бусад бараа, бүтээгдэхүүнтэй харьцуулахад илүү тогтворгүй өсөлт, бууралт илүү ихтэй байдаг нь “нийлүүлэлтийн шок” (supply shock) гэдэг үзэгдэл манайд байнга гарч байгаатай холбоотой. Энэ нь хөдөө аж ахуйн болон импортын хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэлт улирлын хамааралтай огцом өсөж, буурч байдагтай холбоотой үзэгдэл юм. Тухайлбал, монголчуудын хүнсний гол хэрэглээ болох малын махны нийлүүлэлт улирлын чанартай, намар, өвөл мал тарган үед болон өвлийн идэш бэлтгэх үеэр махны нийлүүлэлт нэмэгдэж, үнэ нь буурдаг. Үүний зэрэгцээ малчид оюутан хүүхдийнхээ сургалтын төлбөрийг төлөхийн тулд 8-9 сард мал олноор нь нядалж, махаа борлуулж, орлогоор нь сургалтын төлбөрийг төлдөг. Монголчууд хавар, зуны эхээр хүйтэн хахир өвлийг дөнгөж давж, сульдаж турсан малыг нядалдаггүй, нядлахад махны гарц нь бага ашиггүй байдаг бөгөөд энэ үед махны нийлүүлэлт эрс багасаж, үнэ нь нэмэгддэг онцлогтой. Газар тариалангийн бүтээгдэхүүний хувьд ч мөн нийлүүлэлт нь улирлын шинжтэй ихэсч, буурдаг. Намар төмс, хүнсний ногоо хураан авсны дараа нийлүүлэлт ихсэж, үнэ нь буурдаг бол хавар, зун нийлүүлэлт багасаж, үнэ нь өсдөг. Хүнсний ногоо хадгалах зоорины аж ахуй муу хөгжсөн, ногоо хадгалах зоорь хүрэлцээгүйгээс газар тариалан эрхэлдэг аж ахуй, иргэд ногоогоо жилийн турш жигд нийлүүлж, борлуулж чаддаггүй нь үүнд бас нөлөөлдөг.

Иймээс макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангаж, инфляцийн огцом өсөлтийг гаргуулахгүй байхын тулд Засгийн газар “нийлүүлэлтийн шок”-ыг аль болох арилгах бодлогыг урт хугацаанд авч хэрэгжүүлэх шаардлагатай нь харагдаж байна. 2013 оны 11 дүгээр сараас эхлэн хэрэгжиж эхэлсэн “Хүнсний бүтээгдэхүүний зоорь, агуулахыг нэмэгдүүлэх, эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх” дэд хөтөлбөр хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэлтийн улирлын хэлбэлзлийг багасгах, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нийлүүлэлтийг тогтвортой байлгахад чухал ач холбогдолтой юм.

2.3. Бусад субъектив хүчин зүйлс

Манай орны нэг онцлог нь өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өсөхөд субъектив хүчин зүйлийн нөлөө их, түүнийг хязгаарлах хууль эрх зүйн тогтолцоо сул байдагт оршдог. Товчоор хэлбэл, бараа, бүтээгдэхүүн нь үйлдвэрлэгч, импортлогчдоосоо хэрэглэгчид хүртэлх шат дамжлага олонтой, аль ч шатанд нь хэн нэг нь дураараа үнэ өсгөх боломж ихтэй байдаг. Өмнөх олон жилийн практикаас харахад төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлэхэд бараа, бүтээгдэхүүний үнийг дагаад өсгөдөг, шатахууны үнэ

нэмэгдэхэд бараа, үйлчилгээний үнийг түүнээс илүү өндөр хурдацтай нэмэгдүүлэх, валютын ханшны өсөлтөөр шалтгаалан үндэслэлгүй үнээ нэмэгдүүлэх зэрэг үзэгдэл байнга гардаг. Энэ бүхнийг хуулиар сайтар зохицуулах, хяналт тавих чиглэлээр Засгийн газраас явуулж байгаа үйл ажиллагаа хангалтгүй байгаа юм. Шударга өрсөлдөөн, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах агентлаг зарим талаар тэмцэл явуулж байгаа боловч төрийн байгууллагуудын уялдаа холбоо муу байгаа нь үүнд нөлөөлдөг.

Хуулийн засаглал сайтай, хөгжингүй орнуудад үнэ хэдийгээр зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн харьцаагаар тогтдог гэж үздэг боловч үнийг үндэслэлгүй дураараа өсгөх боломж байдаггүй. Ийм учраас л энэхүү судалгаанаас шилжилтийн эдийн засагтай орнуудад инфляци өндөр өсөлттэй, хөгжингүй орнуудад харьцангуй багаар өссөнийг харж болно. Хөгжингүй орнуудад үнэн хэрэгтээ төрөөс нь өргөнхэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнийг сайтар хянаж, зохицуулж байдаг хууль эрх зүйн орчин үйлчилдэг. Энэ асуудлыг тусгайлан судлах шаардлагатай.

Манай оронд гадаад болон дотоод худалдаа, үүний дотор бөөний болон жижиглэн худалдааны үйл ажиллагааг зохицуулах худалдааны тухай хууль одоо болтол байхгүй байгаа нь дотоодын болон импортын өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнийг хянах, зохицуулах боломж олгодоггүй бөгөөд эндээс бараа, үйлчилгээний үнэ, тариф субъектив хүчин зүйлийн нөлөөгөөр байнга өсч байх нөхцөл бүрдсэн байдаг. Уг нь худалдааны тухай хуулиар худалдааны харилцаанд оролцогчдын эрх, үүрэг, тавигдах шаардлага, ялангуяа үнэ бүрдэлтийн механизмын талаар болон үнийг үндэслэлгүй өсгөхгүй байх талаар тодорхой зохицуулалт оруулсан байх шаардлагатай.

Олон улсын практикаас үзэхэд жижиглэн худалдааны цэг, салбар, дэлгүүр нь бөөний худалдааны баазаас авсан барааны үнэ дээр 20 хүртэл хувийн худалдааны нэмэгдэл нэмж, жижиглэн худалдааны үнэ тогтоодог. Үүнээс өндөр тогтооволүнийн зөрүүгээс олсон бүх орлогоо хураалгаж дээр нь их хэмжээний торгууль төлдөг. Ийм байдлаар хүн амын өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнэнд хяналт тавих боломж бүрдсэн байдаг.

Манай орны хувьд бөөний худалдааг эрхлэх зөвшөөрлийг бараа, бүтээгдэхүүнийхээ хилийн болон дотоодын үнийг төрийн онцгой хяналтанд байлгах нөхцөлтэйгөөр зохих шаардлага хангасан, цөөхөн компаниудад олгоод жижиглэн худалдаа эрхлэгчид зөвхөн бөөний худалдаанаас бараа, бүтээгдэхүүнээ авдаг журамд оруулж, жижиглэнгийн худалдаачдыг өөрсдөө импортоор өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүн оруулахыг хориглосон тохиолдолд өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнийг бүрэн хянах боломжтой болно.

Бараа, бүтээгдэхүүн нийлүүлэгч болон худалдааны байгууллагаар дамжин эцсийн хэрэглэгчдэд хүрэх бүх шатанд бөөний болон жижиглэн худалдааны үнэ, тариф хэрхэн бүрэлдэх, худалдааны нэмэгдлийг яаж тооцох, түүнд ямар зардлуудыг хамруулах, үнэ бүрдэлтийн дээрх бүх үе шатанд хяналтын ямар механизм ажиллуулах, ямар хариуцлага

тооцох зэргийг маш нарийн тогтоосон үнэ, тариф бүрдэлтийн эрх зүйн зохицуулалт үгүйлэгдэж байна. Энэ бүхнийг хуульчлан тогтоож өгсөн тохиолдолд төрөөс үнэ, тарифын өсөлтөд үр нөлөөтэй хяналт тавьж, улмаар инфляцийн өсөлтийг хязгаарлах боломжтой болох юм.

Эцэст нь үнийг тогтворжуулахад зах зээл дэх тэгш, шудрага өрсөлдөөнийг бий болгох, дангаар ноёрхох, үгсэн тохирч үнээ нэмэгдүүлэх явдлийг хязгаарлахад чиглэсэн хууль эрх зүйн одоогийн зохицуулалтыг улам боловсронгуй болгох болон зохион байгуулалтын арга хэмжээг авах зайлшгүй шаардлагатай байна.

2.4. Валютын ханшны инфляцид үзүүлсэн нөлөөлөл

Монгол Улсын эдийн засгийн сүүлийн жил гаруй хугацаанд гол тулгамдсан асуудал нь төгрөгийн ханшны огцом уналт юм. Ам.долларын жилийн дундаж ханш 2010 онд 1335,9 төгрөг байсан бол 2011 онд 1265,5 болж буурч, харин 2012 онд 1359,4 төгрөг болж бага зэрэг өсжээ. Эндээс 2010-2012 онд ам.долларын ханш харьцангуй тогтвортой, өчүүхэн бага өөрчлөлттэй байжээ. Гэтэл 2013 оны 7 сараас төгрөгийн ханш огцом унаж, 8 дугаар сард нэг ам.долларын сарын дундаж ханш 1517,7 төгрөг болж, 11-р сард бүр 1733,5 төгрөг болж чангарсан бол 2014 ондоо аажмаар улам чангарч, 2014 оны 8 дугаар сард хамгийн өндөр түвшиндээ буюу 1862.2 төгрөгт хүрсэн нь Зураг 2,8-аас харагдаж байна. 2013 онд төгрөгийн ам.доллартай харьцах жилийн дундаж ханш 1525,7 төгрөг болсон билээ.



Эх үүсвэр: www.mongolbank.mn

Валютын ханшны чангаралт нь төлбөрийн тэнцлийн урсгал тэнцэлийн алдагдал огцом нэмэгдэж, валютын эрэлт огцом өссөнтэй холбоотой байна. 2010 онд урсгал тэнцэл 886,7 сая долларын алдагдалтай байсан бол 2011 онд алдагдлын хэмжээ 2,7 тэрбум, 2012 онд бүр 3.4 тэрбум ам. доллар, 2013 онд 3.2 тэрбум болж нэмэгдсэн байна. Урсгал тэнцлийн алдагдал ийнхүү огцом өсөхөд барааны болон үйлчилгээний худалдааны аль аль нь ихээхэн алдагдалтай гарсанаас болжээ. Үүний гол шалтгаан нь 2012 оны эцсээр “Чингэс”

бондыг арилжиж, 1.5 тэрбум ам.долларын хөрөнгө босгож, түүнийхээ үлэмж хэсгийг 2013 оны хавраас тодорхой төсөл хөтөлбөрүүдэд зориулан төгрөгөөр зарцуулж, бүтээн босголтын ажлууд өрнөж эхэлснээс импортын бараа, бүтээгдэхүүний эрэлт эрс нэмэгдэж, импортын хэмжээ экспортоосоо эрс давах болж, гадаад худалдааны алдагдал эрс өссөнтэй холбоотой байна. Тухайлбал, 2013 оны 7 сарын импортын хэмжээ 727.2 сая ам.долларт хүрсэн нь өмнөх онуудын аль ч сард хүрч байгаагүй өндөр түвшин байлаа. Яг энэ үед долларын ханш огцом өсөж эхэлсэн байдаг. Үүний зэрэгцээ 2013 он гарсаар манай нүүрсний үнэ унаж, нүүрсний экспорт багассанаар гадаад худалдааны алдагдал нэмэгдэх нэг нөхцөл бүрдсэн билээ. Энд гадаадын шууд хөрөнгө оруулалт 2012 онд 4.4 тэрбум ам.доллар байснаа 2013 онд 2.3 тэрбум болж буурсан нь гаднаас орох валютын урсгал саарч, бүтээн босголттой холбоотой импортын хэрэгцээг хангах валютын эрэлт их өссөнтэй давхцсан байна. Энэ бүхэн нь төгрөгийн ханш эрс суларч, валютын ханш огцом өсөх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Одоо бид валютын ханшны энэ өсөлт Монгол Улсын дотоодинфляцид хэрхэн нөлөөлснийг авч үзье. Монгол Улсын эдийн засаг хөгжихийн хэрээр дэлхийн эдийн засгаас улам хамааралтай болж байна. Монгол улс 2013 онд дэлхийн 146 оронтой худалдаа хийж, урьдчилсан дүнгээр нийт бараа эргэлт 11.1 тэрбум ам.долларт хүрсэн байна. Эндээс харахад дэлхийн эдийн засагт бараа бүтээгдэхүүний үнэ өөрчлөгдөхөд Монголд шууд болон шууд бусаар ХҮИ-г өөрчлөгдөхөд нөлөөлөхөөр байна.

Манай орны хувьд валютын ханш нь импортоор оруулж ирдэг хүн амын өргөн хэрэглээний гол нэрийн барааны үнээр дамжин нөлөөлдөг гол суваг байгаа юм. Валютын ханш чангарахад экспортлогчдод ашигтай, харин импортлогч нарт алдагдалтай байдаг. Учир нь ханш нь чангарсан долларыг худалдан авахад үндэсний мөнгөн тэмдэгтээрээ өмнөхөөсөө илүү өндөр үнээр авдаг билээ. Тухайлбал, долларын ханш харьцангуй тогтвортой байсан 2012 онд нэг ам. доллар 1359,4 төгрөг байсан бол 2013 оны дундаж ханш 1525,7 төгрөг болж доллар тутмаас 166,3 төгрөг илүү зарцуулахад хүрчээ. Өмнөхөөсөө өндөр үнээр авсан валютаар импортоор авсан бараа, бүтээгдэхүүний дотоодын зах зээл дээрх үнэ өсөхөөс өөр замгүй болдог.

Улаанбаатар хотын хүн амын хэрэглээний сагсанд байгаа 329 нэр төрлийн бараа, үйлчилгээний 55.3 хувь нь болох 182 нэр төрлийн бараа, үйлчилгээ нь импортынх байдаг.

Иймээс бил Үндэсний статистикийн хорооны мэргэжилтнүүдтэй хамтран ХҮИ-ийн 2013 болон 2014 оны 8 сарын тооцоонд дээрх 182 нэр төрлийн импортын бараа, бүтээгдэхүүний үнийг 2011-2012 оны дундаж өсөлтөөр нь авч, ХҮИ-ийг шинээр тооцсон тооцооны үр дүнг доорх хүснэгтээр харуулав. Өөрөөр хэлбэл, импортын бараа, бүтээгдэхүүний үнэ валютын ханш үндсэндээ тогтвортой байсан 2011-2012 оны үеийн хэмжээндээ байсан бол ХҮИ ямар байхыг тооцсон болно.

Хүснэгт-2.1. Хэрэглээний үнийн өсөлтөд импортын бараа бүтээгдэхүүний үнийн өөрчлөлтийн нөлөө

	Бодит үр дүн			Тооцооллын үр дүн			Зөрүү		
	2013.12/ 2012.12	2014.08/ 2013.12	2014.08/ 2012.12	2013.12/ 2012.12	2014.08/ 2013.12	2014.08/ 2012.12	2013.12/ 2012.12	2014.08/ 2013.12	2014.08/ 2012.12
Ерөнхий индекс	111.2	107.4	119.4	109.2	107.3	117.1	2.0	0.1	2.3
Хүнсний бараа, ундаа, ус	110.5	107.2	118.5	107.9	107.4	116.0	2.6	-0.2	2.5
Согтууруулах ундаа, тамхи	111.7	105.7	118.0	106.9	109.6	117.2	4.8	-4.0	0.8
Хувцас, бөс бараа, гутал	113.4	105.7	119.9	108.1	104.2	112.6	5.4	1.5	7.3
Орон сууц, ус, цахилгаан, түлш	108.4	105.3	114.1	108.2	105.2	113.8	0.2	0.1	0.3
Гэр ахуйн тавилга, бараа	120.7	104.6	126.2	116.1	105.6	122.5	4.6	-1.0	3.7
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	121.7	108.6	132.2	120.8	108.3	130.8	0.9	0.4	1.4
Тээвэр	101.6	109.6	111.4	101.6	107.3	109.1	0.0	2.3	2.3
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	99.8	100.7	100.6	99.7	100.8	100.6	0.1	-0.1	0.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	98.0	108.0	105.8	96.4	109.6	105.7	1.6	-1.7	0.1
Боловсролын үйлчилгээ	128.4	117.7	151.1	128.4	117.7	151.1	0.0	0.0	0.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	117.5	104.6	122.9	117.5	104.6	122.9	0.0	0.0	0.0
Бусад бараа, үйлчилгээ	121.0	107.8	130.5	119.4	108.3	129.3	1.6	-0.5	1.2

Эх үүсвэр: ҮСХ, ХҮИ-ийн дэлгэрэнгүй тооцоо.

Улаанбаатар хотын хэмжээнд бодит байдал дээрээ хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2013 оны эцэст 2012 оны эцсийнхээс дунджаар 11,2 хувь өссөн билээ. Тооцооноос үзэхэд 2013 онд импортын бараа, бүтээгдэхүүний үнэ өмнөх 2 жилийн дундаж хэмжээндээ байсан бол хотын дүнгээр хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн өсөлт 9,2 хувь буюу нэг оронтой тоонд байх байжээ. Эндээс 2013 оны инфляцийн өсөлтийн хувийн 2 пункт нь цэвэр импортын бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс бий болжээ. Харин 2014 оны 8 сарын байдлаар валютын ханш инфляцид үндсэндээ нөлөөлөөгүй дүн гарлаа. 2014 оны 8 –р сарын байдлаар хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн оны эхэнтэй харьцуулсан дундаж өсөлт нийслэлд 7.4 хувь байсан бол импортын үнийн өсөлтийг оруулаагүй өсөлт 7,3 хувь байна.

Бусад судалгааны үр дүн ч мөн валютын ханш импортын бараагаар дамжин инфляцид нөлөөлдөгийг нотлож байна. Долларын ханш 1 хувиар өсөхөд хүнсний бараа бүтээгдэхүүний үнэ ойролцоогоор 0.3 пунктээр нэмэгдэж байгааг судлаачид тогтоожээ. Төгрөгийн ханш сулрах нь хүн амын амьжиргааны түвшинд хүндээр тусах нь тодорхой байна. 2013 оны 3 сараас өмнөх 27 сарын импортын хүнсний бараа бүтээгдэхүүний үнийн хэлбэлзлийн 30 орчим хувь нь долларын ханшны өөрчлөлтөөр тайлбарлагдаж байсныг судлаачид регрессийн шинжилгээгээр тогтоожээ.¹⁰ Ингэхдээ

¹⁰ Б.Энх-Амгалан, Б.Батмөнх, “Монгол Улсын хэрэглээний үнийн индексэд хүнсний бүтээгдэхүүний үнийн үзүүлэх нөлөө болон олон улсын туршлага”, АХБ-наас санхүүжүүлсэн судалгааны ажлын тайлан, 2014 он

валютын ханшны импортын барааны үнэд үзүүлэх нөлөө ойролцоогоор 4 сар орчим үргэлжилдэг бөгөөд ханш өөрчлөгдсөнөөс хойш 2 дахь сардаа хамгийн өндөр нөлөөтэй байдаг байна. Энэхүү судалгаа нь долларын ханш харьцангуй тогтвортой байх үед хийгдсэн бөгөөд хэрэв 2013 оны 7 сараас хойшхи долларын ханшны чангаралтыг тооцвол бүр ч их нөлөөтэй гарах байсан.

Хөгжиж буй улс орнууд ялангуяа уул уурхай, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспорт дээр эдийн засаг нь тулгуурлаж явдаг улсуудын хувьд экспортын бүтээгдэхүүний бууралт нь эдийн засгийг хямралд оруулах, валютын хомсдол үүсч, улмаар валютын ханшны чангаралт болж, улмаар инфляцийг хөөрөгдөх аюулыг дагуулж байдгийг Монгол Улсын эдийн засгийн сүүлийн 3 жилийн байдал харууллаа.

Бүлэг-3. Үнийн өсөлтийг бууруулах талаар төр, засгийн зүгээс сүүлийн 3 жилд гаргасан тогтоол, шийдвэр, түүний хэрэгжилт

Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн “Ажилтай, орлоготой монгол хүн” гэсэн нэгдүгээр бүлгийн зорилтуудыг хэрэгжүүлэхийн тулд хийх шинэчлэлтийн дотор “инфляцид хөтлөгдөх бус зохицуулах тогтолцоонд шилжих”, “инфляцийг нэг оронтой тоонд барьж, төгрөгийн худалдан авах чадварыг тогтвортой байлгах” зорилтуудыг дэвшүүлсэн. Энэ нь шинэчлэлтийн Засгийн газраас инфляцийн талаар баримтлах гол бодлого юм.

Өмнөх он жилүүдийн практикаас харахад манай оронд дараах нэр төрлийн бараа, үйлчилгээний үнэ, тарифыг төрөөс тодорхой хэмжээгээр хянаж, зохицуулсаар ирсэн байдаг. Үүнд:

1. Ахуйн хэрэглээний цахилгааны 1 квт цагийн төлбөр
2. Шатахууны үнэ
3. Автобусны билетийн үнэ
4. Орон сууцны халаалтын үнэ
5. Ундны цэвэр усны үнэ
6. Их, дээд сургуулийн сургалтын төлбөр
7. Үр тариа улсад худалдан авах үнэ, урамшуулал
8. Гурилын үнэ
9. Талхны үнэ
10. Махны үнэ

Эдгээр бараа, бүтээгдэхүүнээс цахилгааны, шатахууны болон үр тарианы үнэбусад бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний зардлыг нэмэгдүүлж, улмаар үнэд нь шууд нөлөөлдөг тул зайлшгүй хяналтад байлгах шаардлагатай. Харин үлдсэн 7 нэр төрлийн хувьд хүн амын хэрэглээнд өндөр хувийн жин эзэлдэг тул эдгээр нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний үнэ өсөхөд хүн амын амьжиргаанд шууд муугаар нөлөөдөг учраас төрөөс хянаж,

зохицуулсаар ирсэн. Гэхдээ зохицуулалтын арга хэрэгслүүд нь бүтээгдэхүүн, үйлчилгээ бүрд өөр өөр байсан билээ.

Сүүлийн 2 жил гаруй хугацаанд Монгол Улсын Засгийн газар Монголбанктай 2012 оны 10 дугаар сарын 22-нд байгуулсан “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөр”-ийг хамтран хэрэгжүүлэх харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд дараах 5 дэд хөтөлбөрүүдийг холбогдох байгууллагуудтай хамтран баталж, хэрэгжүүлж ирлээ. Үүнд:


1. Шатахууны жижиглэнгийн үнийг тогтворжуулах дэд хөтөлбөр
2. Өргөн хэрэглээний импортын бараа, бүтээгдэхүүний өртгийг бууруулах дэд хөтөлбөр
3. Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дэд хөтөлбөр
4. Барилгын салбарыг дэмжих, улмаар орон сууцны үнийг тогтворжуулах дэд хөтөлбөр
5. “Нүүрсний аюулгүйн нөөц бүрдүүлэх, түлш, эрчим хүчний салбарын өвөлжилтийн бэлтгэл хангах, эрчим хүчний үнэ, тарифыг тогтворжуулах” дэд хөтөлбөр

3.1. Шатахууны жижиглэнгийн үнийг тогтворжуулах дэд хөтөлбөрийн хэрэгжилт

Өргөн уудам нутаг дэвсгэртэй манай орны хувьд шатахууны үнэ нь бусад бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ, тарифад хүчтэй нөлөөлж, улмаар инфляцийн түвшинд шууд нөлөөлдөг онцлогтой.

Шатахууны жижиглэнгийн үнийг тогтворжуулах дэд хөтөлбөрийг Монголбанкны Ерөнхийлөгч болон Уул уурхайн сайдын 2012 оны 10 дугаар сарын 26-ний өдрийн хамтарсан тушаалаар баталсан. Энэхүү хөтөлбөрийн гол зорилго нь газрын тосны бүтээгдэхүүний импортыг Монголбанкнаас тогтоосон хүүгээр санхүүжүүлэх, валютын ханшны өөрчлөлтөөс хамаарах нөлөөллийг бууруулах замаар жижиглэнгийн худалдааны үнийг тогтвортой байлгахад оршиж байв.

Зураг-3.1. Шатахууны жижиглэнгийн үнийн суурь үетэй (2012 оны 9 сар) харьцуулсан өсөлт, хувиар, 2012.IX=100



Эх үүсвэр: ҮСХ, ХҮИ-ийн хэрэглээний сагсны задгай нэр төрлүүдийн үнэ

2012 оны 9 сараас 2014 оны 12 сарын хоорондох хугацаанд шатахууны үнэ 5 удаа, тухайлбал, 2012 оны 11, 12 –р саруудад 2,9-3,4 хувиар, 2014 оны 1-3 саруудад 0.3-1.2 хувиар өсөж байсан боловч 2013 оны 6 сард 2.8-3.2 хувиар, 2014 оны 5 сард 0.3-0.6 хувиар тус тус 2 удаа буурч байжээ. Зургаас харахад шатахууны жижиглэнгийн үнийг тогтворжуулах дэд хөтөлбөрийн хэрэгжилт сайн, 2014 оны 12 сарын байдлаар шатахууны үнэ 2012 оны 9 сарынхаас ердөө 4.7-5.7 хувиар л дээгүүр, шатахууны үнийг тогтворжуулах зорилт үндсэндээ амжилттай хэрэгжсэн байна.

3.2. “Өргөн хэрэглээний импортын бараа, бүтээгдэхүүний өртгийг бууруулах” дэд хөтөлбөрийн хэрэгжилт

Өргөн хэрэглээний импортын бараа, бүтээгдэхүүний өртгийг бууруулах дэд хөтөлбөрийг Монгол банкны Ерөнхийлөгч болон Зам, тээврийн сайдын хамтарсан тушаалаар 2012 онд баталсан. Дэд хөтөлбөрийн зорилго нь гадаад худалдааны тээвэр, ложистикийн дэд бүтцийг сайжруулах замаар өргөн хэрэглээний импортын бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн жигд, тасралтгүй байдлыг хангах, үний өсөлтийг хязгаарлахад оршиж байв. Хөтөлбөрийг 2012 оны 10 дугаар сараас эхлэн хэрэгжүүлж эхэлсэн байна. Энэхүү дэд хөтөлбөрийг 3 жил хүртэлх хугацаанд хэрэгжүүлж, нийтдээ 303 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсөн.

Энэхүү хөтөлбөрийн хэрэгжилтийг дүгнэхийн тулд нэмэлт тусгай судалгаа явуулах шаардлагатай юм. Учир нь энэхүү хөтөлбөр нь бараа, бүтээгдэхүүний үнэ биш, харин өртгийг бууруулах зорилготой билээ. Гадаад худалдааны тээвэр, ложистикийн дэд бүтцийг сайжруулснаар бараа, бүтээгдэхүүний өөрийн өртөг хямдарсан байдлыг тусгайлан судлах шаардлагатай. Хэдийгээр ийм судалгаа хийгдээгүй боловч ам.доллар, юаны ханш өссөний улмаас импортын өргөн хэрэглээний барааны үнэ нэмэгдэж, улмаар инфляцийн түвшинд сөргөөр нөлөөлсөн тул хөтөлбөрийн эцсийн үр дүнд таагүй нөлөөлсөн билээ.

3.3. “Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах” дэдхөтөлбөрийн хэрэгжилт

“Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөрийг Монголбанкны Ерөнхийлөгч болон Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын хамтарсан тушаалаар 2012 оны 10 дугаар сард баталсан.

Энэхүү хөтөлбөр нь хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтвортой байлгах ойрын зорилттой, хүнсний бараа, бүтээгдэхүүний агуулахын үлдэгдлээр баталгаажих санхүүгийн хэрэгслүүдийг нэвтрүүлэн, хүнсний бараа, бүтээгдэхүүний хангамжийн зах зээлд суурилсан байнгын тогтолцоо бүрдүүлэх хэтийн зорилготой.

Дэд хөтөлбөрийг 3 жилийн хугацаатай нийтдээ 248 тэрбум төгрөгийн санхүүжилтээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Энэхүү дэд хөтөлбөр нь дотроо дараах бүрэлдэхүүн хэсгүүдтэй. Үүнд:

1. Махны нөөцийн менежерт хөнгөлөлттэй эргэлтийн зээл олгож, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах замаар махны жижиглэнгийн худалдааны үнийг тогтворжуулах нөхцөлийг тогтмол хангах зорилго бүхий “Махны нөөц бүрдүүлэх, үнийг тогтворжуулах” хөтөлбөр (Санхүүжилт: 87 тэрбум төгрөг)

2. Гурилын үйлдвэрүүдэд шинэ ургацын хүнсний буудай худалдан авахад хөнгөлөлттэй зээлийг олгох замаар гурилын жижиглэнгийн худалдааны үнийг тогтворжуулах нөхцөлийг тогтмол хангах зорилго бүхий “Гурилын үнийг тогтворжуулах” хөтөлбөр (Санхүүжилт: 61 тэрбум төгрөг)

3. Хүнсний зориулалттай зоорь, агуулах барих сонирхолтой хувийн хэвшилд хөнгөлөлттэй зээл олгох замаар стандартын шаардлага хангасан олон тооны зоорь, агуулах барих нөхцөлийг бүрдүүлэх зорилго бүхий “Хүнсний бүтээгдэхүүний зоорь, агуулахыг нэмэгдүүлэх, эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх” хөтөлбөр (Санхүүжилт: 100 тэрбум төгрөг)


“Махны нөөц бүрдүүлэх, үнийг тогтворжуулах” хөтөлбөрийн хэрэгжилт. 2013 онд дэд хөтөлбөрийн хүрээнд Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотын хүн амын хэрэгцээнд зориулан нөөцийн махны менежер “Жаст Агро” ХХК, “Эрдмийт” ХХК, “Баатрууд тэнгэр” ХХК-иуд нийт 11,461.8 тонн махны нөөцийг 87 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлээр бэлтгэн, худалдан борлуулах үйл ажиллагааг зохион байгуулсан байна. Зээлийн эх үүсвэр бүрэн төлөгдөж, нөөцийн махыг борлуулж дууссан. 2014 онд Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотуудад “Баатрууд тэнгэр” ХХК 6001.6 тонн, “Эй Эн Ди Эм” ХХК 6560.3 тонн, “Дархан мийтфүүд” ХХК 1000.0 тонн, “Эрдмийт” ХХК 1001.5 тонн нөөцийн мах бэлтгэн, сертификатаар баталгаажуулан борлуулж байна. УИХ-ын 2013 оны 11 дүгээр сарын 14-ний 62 дугаар тогтоолын 4.1-д заасны дагуу хөтөлбөрийг зах зээлийн механизмд суурилсан хэлбэрт шат дараатай шилжүүлэх зорилгоор хөтөлбөрийн зээлийн 20%-ийг банкны өөрийн эх үүсвэрээр, 80%-ийг Монголбанкны эх үүсвэрээр санхүүжүүлжээ. Хөтөлбөрийн хүрээнд банкууд нөөцийн менежер компаниудад 77.0 тэрбум төгрөгийн

хөнгөлөлттэй зээл олгосон байна. Нөөцийн махны менежерүүд хонины мах 6500.0 тонн (44.6 хувь), ямааны мах 3276.5 тонн (22.5 хувь), үхрийн мах 4787.0 тонн (32.9 хувь), нийт 14,563.4 тонн мах бэлтгэсэн байна.

Нөөцийн махны худалдааг 2013 оны 12-р сарын 25-ны өдрөөс эхлэн зохион байгуулж, 2014 оны 7-р сарын 31-ний өдрийн байдлаар 13944.4 тонн (нийт бэлтгэсэн махны 95.7%) махыг борлуулж, хуваарийн дагуу нийт 77.0 тэрбум төгрөг буюу нийт зээлийг 100% буцаан төлжээ.

Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны албан ёсны тайлангаар 2010-2012 оны дунджаар Улаанбаатар хотын жилийн инфляцийн 3.6%-ийг махны үнийн өсөлт тодорхойлдог байсан бол 2013 онд дунджаар 1.9%, 2014 оны эхний 9 сарын байдлаар 0.7% болж буураад байгаа ажээ. Эдгээрээс дүгнэхэд дэд хөтөлбөр нь ойрын зорилгодоо хүрсэн гэж үзэж байна гэж дүгнэжээ.

Зураг-3.2. Махны жижиглэнгийн үнийн суурь үетэй (2012 оны 12 сар) харьцуулсан өсөлт, хувиар, 2012.XII=100



Эх үүсвэр: ҮСХ, Статистикийн 2013-2014 оны сар бүрийн бюллетень


Зургаас харахад 2013 оны 10-12 саруудад махны үнэ улирлын шинжтэй нийлүүлэлтийн улмаас нэлээд хэмжээгээр буурч, 2014 оны 1 дүгээр сараас эргээд өссөн боловч 2014 оны 12 сарын байдлаар хонь, адууны махны үнэ 2012 оны эцийнхээсээ 1.5-6.8 хувиар буурсан, харин ямааны махны үнэ 1,6 хувиар, үхрийн ястай махны үнэ 4,1 хувиар нэмэгджээ. Эндээс үзэхэд харин махны үнийг тогтворжуулах хөтөлбөр одоогоор үндсэндээ зорилгоо хангасан гэж дүгнэж болохоор байна.

“Гурилын үнийг тогтворжуулах” хөтөлбөрийн хэрэгжилт 2013 онд дэд хөтөлбөрийн хүрээнд гурилын үйлдвэрүүдийн улаан буудай худалдан авахад хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлэхээр Монголбанкнаас дотоодын банкуудад зээл олгож, банкууд нийт 61 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 36 гурилын үйлдвэрт олгохоор төлөвлөсөн бөгөөд

23 гурилын үйлдвэрт нийт 48.7 тэрбум төгрөгийн зээлийг олгосон. Үүнээс 2014 оны 4 дүгээр сарын байдлаар нийт 43.7 тэрбум төгрөгийг эргүүлэн төлснөөр 21 гурилын үйлдвэр зээлээ бүрэн буцаан төлөөд байна. Харин үлдэгдэл 5 тэрбум төгрөгийн зээлийг эргэн төлөх хуваарийн дагуу 2014 оны 7 дугаар сард төлж дууссан байна.

2014 онд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, хүнсний бараа, бүтээгдэхүүний агуулахын үлдэгдлээр баталгаажих санхүүгийн хэрэгслүүдийг нэвтрүүлэн, хүнсний бараа, бүтээгдэхүүний хангамжийн үр ашигтай, зах зээлийн зарчимд суурилсан байнгын тогтолцоог бүрдүүлэх зорилготой ажиллаж байна. УИХ-ын 2013 оны 11 дүгээр сарын 14-ний 62 дугаар тогтоолын 4.1-д заасны дагуу хөтөлбөрийг зах зээлийн механизмд суурилсан хэлбэрт шат дараатай шилжүүлэх зорилгоор хөтөлбөрийн санхүүжилтийн 40%-ийг банкны өөрийн эх үүсвэрээр, 60%-ийг Монголбанкнаас банкинд олгосон зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлэн, 2014 оны 10 дугаар сарын 23-ны байдлаар 27.0 тэрбум төгрөгийг 9 гурилын үйлдвэрт олгоод байна. Мөн агуулахад байгаа улаан буудайг сертификатаар баталгаажуулан борлуулах зах зээлийн шинэ хэрэгсэл нэвтрүүлэхээр ажиллаж байгаа ажээ.

Зураг-3.3. Гурилын жижиглэнгийн үнийн суурь үетэй (2012 оны 12 сар) харьцуулсан өсөлт, хувиар, 2012.XII=100



Эх үүсвэр: ҮСХ, Статистикийн 2013-2014 оны сар бүрийн бюллетень

Зургаас харахад 2012 оны эцэстэй харьцуулахад дээдийн дээд гурилын үнэ 2014 оны 12 сар гэхэд 43,9 хувь, дээд гурилын үнэ 34 хувиар нэмэгдсэн байна. Эндээс гурилын үнийг хөтөлбөр хэрэгжүүлсэн хугацаанд сайн барьж чадаагүй байна.

“Хүнсний бүтээгдэхүүний зоорь, агуулахыг нэмэгдүүлэх, эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх” дэд хөтөлбөрийн хэрэгжилт. “Хүнсний бүтээгдэхүүний зоорь, агуулахыг нэмэгдүүлэх, эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх” дэд хөтөлбөр 2013 оны 11 дүгээр сараас эхлэн хэрэгжиж эхэлсэн бөгөөд уг хөтөлбөрийн хүрээнд зоорийн багтаамжийг нийт 82.6 мянган тонноор нэмэгдүүлж, автомат, хагас автомат удирдлагатай, иж бүрэн механикжсан

ажиллагаатай төмс, хүнсний ногоо, мах махан бүтээгдэхүүний зоорь, агуулах, худалдааны төвүүдийг байгуулах, эрчимжсэн аж ахуйн хөтөлбөрийн хүрээнд 2014 онд 6 мянган тонн, 2015 онд 6.8 мянган тонн, 2016 онд 7.7 мянган тонн нойтон мах нийлүүлэхээр төлөвлөсөн бөгөөд энэ нь гол төлөв 2-7 дугаар сарын нойтон махны нийлүүлэлтийг 15%-иар нэмэгдүүлэх төлөвлөгөөтэй байна.

Дэд хөтөлбөрийн хүрээнд ҮХААЯ-наас 79 аж ахуйн нэгжийн төслийг шалгаруулсан. 2014 оны 10 дугаар сарын 23-ны байдлаар Монголбанкнаас банкинд олгосон зээлийн эх үүсвэрээр банкууд нийт 137.0 тэрбум төгрөгийн зээлийг хөтөлбөрийг хэрэгжүүлэгч 66 компанид олгожээ. Зээл эргэн төлөгдөх хуваарийн дагуу 2017 онд бүрэн төлөгдөж дуусна. ҮХААЯ хөтөлбөрийг хэрэгжүүлэгч зарим компани (Эй Эн Ди Эм ХХК, Хүнс комплекс ХХК, М Ти Эс ХХК, Тэнгэр ХХК, Траст трейд ХХК)-иудын барьж буй зоорь, агуулах 95 хувийн гүйцэтгэлтэй баригдаж байгаа нь удахгүй ашиглалтад орж, дэд хөтөлбөрийн зорилтот үр дүнд хүрэх нөхцөл бүрдэнэ гэж үзэж байна. Хөтөлбөр хэрэгжиж эхлээд удаагүй байгаа тул үр дүн нь хараахан гарч амжаагүй байна.

3.4. Барилгын салбарыг дэмжих, улмаар орон сууцны үнийг тогтворжуулах дэд хөтөлбөрийн хэрэгжилт

Барилгын салбарыг дэмжих, улмаар орон сууцны үнийг тогтворжуулах дэд хөтөлбөрийг Монголбанкны Ерөнхийлөгч болон Барилга, хот байгуулалтын сайдын 2013 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн хамтарсан тушаалаар баталсан.

Хөтөлбөрийн гол зорилгыг орон сууцны эрэлт, нийлүүлэлтийн уялдааг хангах замаар орон сууцны үнэ болон орон сууцны түрээсийн үнийг тогтвортой байлгах, иргэдийн эрүүл, аюулгүй орчин дахь орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлэхэд оршино гэж тодорхойлжээ. Энэхүү хөтөлбөр нь 3 жилийн хугацаатай хэрэгжих бөгөөд дотроо 2 хэсгээс бүрдэнэ.

1. “Барилгын гол нэр төрлийн материалын үнийг тогтворжуулах” хөтөлбөр, санхүүжилтийн нийт дүн 379.0 тэрбум төгрөг

2. “Орон сууцны санхүүжилтийн урт хугацааны тогтвортой тогтолцоог бий болгох” хөтөлбөр, санхүүжилтийн нийт дүн 800.0 тэрбум төгрөг.

3.4.1. “Барилгын гол нэр төрлийн материалын үнийг тогтворжуулах” хөтөлбөрийн хэрэгжилт

2014 оны 5 дугаар сарын эцсийн байдлаар Монголбанк болон Барилга, хот байгуулалтын яамнаас (БХБЯ) хамтран гаргасан тайлангаар Засгийн газартай гэрээ байгуулсан барилгын материал үйлдвэрлэгч дотоодынаж ахуйн нэгжүүдэд эргэлтийн хөрөнгийн хөнгөлөлттэй зээл авч үйлдвэрлэлээ өргөтгө хболомжийг олгох, барилгын гол нэрийн материалын дотоодын нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангахад зориулж 71 компанид 174.7 тэрбум төгрөг, зайлшгүй импортлох шаардлагатай барилгын материал (цемент, арматур)-ын улирлын шалтгаантай нийлүүлэлтийн хязгаарлалтыг арилгахад зориулж 55 компанид 125.4 тэрбум төгрөг, нийт 301.6 тэрбум төгрөгийн зээлийг банкууд олгожээ.


БХБЯ-ны мэдээллээс үзэхэд хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш 2013 онд цемент, арматур импортлогч компаниуд нийт 1,520,000 тонн цемент, 179,198 тонн арматур импортолсон байна. Үүнээс хөтөлбөрийн санхүүжилтээр 490,000 тонн цемент, 161,605 тонн арматур оруулж иржээ.

Барилгын гол нэр төрлийн материалын дотоодын нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах хөтөлбөрийн хүрээнд олгосон санхүүжилтийн үр дүнд нийт 21 үйлдвэр тоног төхөөрөмжөө шинэчилж үйлдвэрлэлээ өргөжүүлсэн, мөн 11 үйлдвэр шинээр байгуулагдсан. Энэ нь барилгын материалын импортын хэмжээг бууруулаад байна.

Түүнчлэн хөтөлбөрийн үр дүнд цемент, арматурын үйлдвэр шинээр ашиглалтанд орж 2014 оны цемент, арматурын дотоодын үйлдвэрлэл нэмэгдэх болсон.

Цементийн үнийг 2013 оны 2, 3 дугаар улиралд 132-138 мянган төгрөгийн хооронд тогтоон гэрээний дагуу ажиллаж үнийг тогтвортой түвшинд байлгасан боловч 2013 оны 8 дугаар сард ханшийн хэлбэлзлээс шалтгаалан цементийн зах зээлийн үнэ 140-145 мянган төгрөг болсон. Хөтөлбөрт хамрагдсан аж ахуйн нэгжүүд гэрээнд заасан үнээр зарах нь алдагдалтай болсон учир цементийн борлуулалтаа зогсоосон. Үүнээс хамааран цементийн импорт эрс буурч 9 болон 10 дугаар сард цементийн үнэ 200 мянган төгрөг хүрч өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь аж ахуйн нэгжүүд БХБЯ-тай байгуулсан гэрээний үүргээ зөрчсөн асуудал юм. Иймээс зайлшгүй импортлох шаардлагатай барилгын материал (цемент, арматур)-ын улирлын шалтгаантай нийлүүлэлтийн хязгаарлалтыг арилгах хөтөлбөрийг 2014 онд үргэлжлүүлэх шаардлагагүй гэж үзсэн.

Зураг 3.4.Цементийн үнийн өөрчлөлт,2000=100, хувиар



Эх үүсвэр: ҮСХ, Статистикийн эмхтгэл-2013 он, 2014 оны эхний 9 сарын статистикийн бюллетень

Зургаас харахад цементийн үнэ тогтворгүй, улирлын ихээхэн хэлбэлзэлтэй байна. Дотоодод үйлдвэрлэдэг цементийн зах зээл дэх үнэ 2014 оны статистик мэдээлэлд нийтлэгдэхгүй байна. Үнийг тогтворжуулах зорилт хангалттай хэрэгжиж чадаагүй тул уг хөтөлбөрийг зогсоожээ. Арматурын төмрийн үнээр албан ёсны статистик мэдээлэл цуглуулахгүй байгаа тул түүний үнийн өөрчлөлтийн талаар дүгнэлт хийх боломж байсангүй.

Орон сууцны 1 кв.метрийн үнийг 2014 оны эхний 9 сарын статистикийн бюллетенд тусгаснаар Улаанбаатар хотын 6 дүүргийн дунджаар 2014 оны 3-р улирлын байдлаар 2013 оны мөн үеийнхээс 10,2 хувиар нэмэгдсэний дотор Чингэлтэй дүүрэгт хамгийн бага буюу дунджаар 6 хувь, Хан-Уул дүүрэгт хамгийн их буюу дунджаар 14 хувь өсжээ. Ялангуяа 2002 оноос хойш баригдсан шинэ орон сууцны үнэ илүүтэй нэмэгдсэн байна.

3.4.2. Орон сууцны санхүүжилтийн урт хугацааны тогтвортой тогтолцоог бий болгох хөтөлбөрийн хэрэгжилт

Ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бий болгох талаар хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичгийг Монголбанк Засгийн газартай 2013 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр байгуулсан. Энэ хүрээнд Монголбанкнаас 2013 оны 6 дугаар сарын 14-ний өдөр баталсан “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журам”-ын дагуу ерөнхий гэрээг банкууд болон МИК-тай байгуулж, өмнө олгосон орон сууцны ипотекийн зээлийг дахин санхүүжүүлэхэд болон шинээр ипотекийн зээл олгоход зориулж 1.7 их наяд төгрөгийг банкуудад байршуулсан байна.

Хөтөлбөрийг 2013 оны 6 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн хэрэгжүүлж эхлэв. Банкууд 2014оны 6 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар 18,378 зээлдэгчийн 528.9 тэрбум төгрөгийн оронсууцны ипотекийн зээлийг дахин санхүүжүүлж, зээлийн хүүг 8%-д шилжүүлжээ. Мөн 20,335иргэнд 1,145 тэрбум төгрөгийн орон сууцны ипотекийн зээл шинээр олгосон байна.

Ийнхүү орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бий болгосноор Монгол Улс хэрэглээний эдийн засгаас хуримтлалтай эдийн засагт шилжих, нийгмийн дундаж давхаргын хуримтлал, бүтээмжийг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн зах зээлийн ил тод байдлыг сайжруулах, нийгмийн даатгалын сангийн орлогыг нэмэгдүүлнэ. Уг тогтолцоо нь эргээд урт хугацаанд инфляцийг бууруулахад эерэгээр нөлөөлж, эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлтийн зорилтыг хангах болно гэж үзэж байна.

Энэхүү хөтөлбөр ажилттай хэрэгжиж, урт хугацаанд ач холбогдолтой байгаа боловч нөгөө талаасаа иргэдийн орон сууцны эрэлтийг их хэмжээгээр нэмэгдүүлсэн тул орон сууцны үнэ өсөх бас нэг нөхцөлийг бий болгосон сөрөг үр дагавартай байна.


1.5. “Нүүрсний аюулгүйн нөөц бүрдүүлэх, түлш, эрчим хүчний салбарын өвөлжилтийн бэлтгэл хангах, эрчим хүчний үнэ, тарифыг тогтворжуулах” дэд хөтөлбөрийн хэрэгжилт

“Нүүрсний аюулгүйн нөөц бүрдүүлэх, түлш, эрчим хүчний салбарын өвөлжилтийн бэлтгэл хангах, эрчим хүчний үнэ, тарифыг тогтворжуулах” дэд хөтөлбөрийг Монголбанкны Ерөнхийлөгч болон Уул уурхайн сайдын 2013 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн хамтарсан тушаалаар баталсан. Энэхүү хөтөлбөр нь түлш, эрчим хүчний төрийн өмчит компаниудад нүүрсний аюулгүйн нөөц бүрдүүлэх, өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зорилгоор банкаар дамжуулан эргэлтийн хөрөнгийн хөнгөлөлттэй зээл олгож, санхүүгийн чадавхид дэмжлэг үзүүлэн түлш, эрчим хүчний нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах, эрчим хүчний үнэ, тарифыг тогтворжуулах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдсэн. Хөтөлбөрийг 24 сарын хугацаанд нийтдээ 80 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн. Хөтөлбөрт хүрэх үр дүнг дараах байдлаар тусгажээ.

- 1.Төрийн өмчит компаниудад 2013-2014 оны нүүрсний аюулгүйн нөөц бүрдэнэ.
- 2.Түлш, эрчим хүчний нийлүүлэлт тасралтгүй, найдвартай байх нөхцөл хангагдана.
- 3.Цахилгаан, дулааны үнэ, тариф тогтвортой байж, зардлын шалтгаантай инфляцийн дарамт буурах суурь нөхцөл бүрдэнэ.

Хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх зорилгоор цахилгаан, дулаан, түлшний үнийн өсөлтийг уг хөтөлбөр батлагдсан 2013 оны 7 сартай харьцуулан доорх хүснэгтэд харуулав.

Зураг-3.5. Цахилгаан, дулаан, түлшний үнийн суурь үетэй (2013 оны 7сар) харьцуулсан өсөлт, хувиар, 2013.VII =100



Эх үүсвэр: YCSX, Статистикийн 2013-2014 оны сар бүрийн бюллетень

Хөтөлбөрийн хэрэгжилтийг хүрэх үр дүнд заасны дагуу зөвхөн цахилгаан, дулааны үнэ, тарифийн хүрээнд дүгнэвэл цахилгааны үнэ 2013 оны 7 сараас 2014 оны 12 сарын хооронд 4 удаа нэмэгдсэний дотор орон сууцанд амьдардаг өрхүүдийн 1 кв.цаг эрчим хүчний тариф 2013 оны 8 сард дунджаар 22.3 хувиар, 2014 оны 8 сард дунджаар 5.2 хувиар, мөн оны 9 сард 2 хувиар, 12 сард 9,9 хувиар, харин гэр хороололд амьдардаг өрхүүдийн 1 кв.цаг эрчим хүчний тариф 2013 оны 8 сард дунджаар 3.9 хувь, 2014 оны 8 сард дунджаар 6.3 хувь, 9 сард 2,1 хувь, 12 сард 9,8 хувиар нэмэгджээ. Эдгээрийн үр дүнд 2014 оны 12 сарын байдлаар орон сууцанд амьдардаг өрхүүдийн 1 кв.цаг эрчим хүчний тариф 2013 оны 7 сарынхаас 44,2 хувь, гэр хорооллынх 23,9 хувиар өсөөд байна.

Харин орон сууцны халаалтын үнэ 2013 оны 9 сард дунджаар 27.1 хувиар, 2014 оны 12 дугаар сард 17,3 хувиар өссөн байна. Бүхэлд нь авч үзвэл цахилгаан, дулааны үнэ, тариф сүүлийн 18 сарын дотор 23,9-49,1 хувиар өссөж, инфляцийн түвшинд багагүй нөлөө үзүүлсэн тул хөтөлбөрийн тавьсан зорилт бүрэн хэрэгжсэн гэж дүгнэхэд учир дутагдалтай байна.

Засгийн газраас “Нүүрс” хөтөлбөрийг хэрэгжүүлж, гэр хорооллын өрхүүдэд Багануурын уурхайгаас хямд үнэтэй шигшсэн нүүрсийг нийлүүлэх ажлыг зохион байгуулж ирсэн боловч 2013 оны 8 сард нүүрсний үнэ дунджаар 4.3 хувь, 2013 оны 10 сард шууд 25 хувиар өссөний улмаас 2014 оны 8 сарыг 2013 оны 7 сартай харьцуулахад нүүрсний дундаж үнэ 30.4 хувиар нэмэгджээ. Харин түлээний модны үнийг зохицуулах талаар ямар нэг арга хэмжээг аваагүй тул түүний үнэ дээрх хугацаанд 47.8 хувиар буюу харьцангуй ихээр нэмэгджээ. Гэхдээ Зураг 3.5 -аас харахад 2013 оны 12 сараас хойш цахилгаан, дулаан, түлшний үнэ харьцангуй тогтвортой болсныг харж болохоор байна.

Бүлэг 4. Бусад улс орнуудад үнийг тогтворжуулах талаар авдаг арга хэмжээ, туршлага

4.1. Үнийг тогтворжуулах стратеги

Эрдэмтэд, судлаачдын үзэж байгаагаар хүнсний бүтээгдэхүүний үнийн тогтворгүй байдал нь орлого болон худалдан авах чадварыг доройтуулж, хүнсний аюулгүй байдал, хүнсний үйлвэрлэлд оруулах хөрөнгө оруулалтын бууралт, макро эдийн засгийн доройтол зэрэг хөгжлийн асуудлуудыг үүсгэхээс гадна улс төрийн тогтворгүй байдалд ч хүргэх аюултай ажээ. Иймд үнийн тогтворгүй байдлыг хоёр хандлагаар шийдвэрлэх боломжтой гэж үздэг. Үүнд: нэгдүгээрт үнийг тогтворжуулах, хоёрт орлого болон худалдан авах чадварыг бууруулж буй үнийн тогтворгүй байдлын нөлөөллийг бууруулах зэрэг нь багтана. Эдгээр хандлага нь зах зээлийг хөгжүүлэх болон төрийн оролцоог хангах арга замуудын аль алиныг ашиглан хэрэгжүүлэх боломжтойгоороо онцлог юм. Дараах матриц нь үнэ тогтворжуулалтын зорилго, хэрэгжүүлэх стратеги болон арга замуудыг нэгтгэн харуулжээ.

Хүснэгт 4.1. Үнэ тогтворжуулалтын стратегийн ABCD матриц

Зорилго Арга зам	Үнэ тогтворжуулах	Үнийн тогтворгүй байдлын нөлөөг бууруулах
Зах зээлийн хөгжил	А стратеги	В стратеги
Төрийн оролцоо	С стратеги	Д стратеги

Эх сурвалж: F. Galtier (2013) “Managing food price instability in developing countries: A critical analysis of strategies and instruments”, (31-р тал)

А стратеги нь үйлдвэрлэл, худалдаа болон хэрэглээг үнэд мэдрэг болгох замаар үнийн тогтворгүй байдлыг зах зээлийн оролцогчид үнийн арбитражаар дамжуулан засварлах боломжийг олгоно. Арбитражийг хугацаа (худалдах, худалдан авах цаг хугацааны сонголт), байршил (хаана худалдах, худалдан авах), бүтээгдэхүүн хооронд (тариаланчид ямар ургамал тарих, өрх гэрүүд ямар бүтээгдэхүүн авахаа сонгох) болон бүтээгдэхүүний технологи хоорондын (тариаланчид, малчид ямар технологийн дэвшил хэрэглэх, тэдгээр нь байгалийн гамшигт хэр мэдрэг байх зэрэг) сонголтоос хамаарч хийнэ. Эдгээр сонголт, шийдвэрүүд нь үнэд суурилан хийгдэх тул нэн тэргүүнд зах зээлд оролцогчдыг үнийн хөдөлгөөний мэдээллээр хангах “Зах зээлийн мэдээллийн систем” зайлшгүй шаардлагатай. Гэхдээ мэдээллээс гадна дэд бүтэц, бордоо, санхүүжилт авах боломж зэрэг бусад хүчин зүйлс нь зах зээлд оролцогчдын шийдвэрт нөлөөлж байдаг тул А стратегийн хэрэгслүүдийг: хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний орцын хангалт (үр, бордоо, услалтын систем, тоног төхөөрөмж, зээл, зөвлөгөө г.м) болон зах зээлийн дэд бүтэц, институци (тээвэрлэлт, зам, харилцаа холбоо, боловсруулалт, хадгалалтын газрууд, улирлын зээллэг, зэрэглэл тогтоолт, бирж г.м) гэсэн 2 үндсэн хэсэгт хувааж болно.

В стратеги нь үйлдвэрлэгч болон худалдаачдад үнийн эрсдлээс өөрсдийгөө хамгаалах боломжийг олгодог. Хэдийгээр фьючерс нь үнийг тогтворжуулах зорилгогүй боловч үнийн тогтворгүй байдлаас үүдэж орлогоо бууруулахгүй байхад тусалдаг нэг ёсны даатгал юм. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний хувьд үр тариа хураалтын эрсдэл нь үнийн эрсдэлтэй холбоотой байдаг тул энэхүү стратеги нь тариа хураалтын эрсдлээс даатгах агуулгыг ч өөртөө багтаадаг. Уг стратегийн хэрэгслүүдийг 3 бүлэгт хуваадаг: фьючерс, даатгал (үр тарианы даатгал, цаг агаарын индексжүүлсэн даатгал) болон зээллэг (үйлдвэрлэгч болон хэрэглэгчийн). Эхний 2 бүлэг хэрэгсэл нь үнэ болон үр тарианы хураалтын эрсдлийн эсрэг хэрэглэгддэг урьдчилсан хамгаалалтын үүрэгтэй бол 3 дахь бүлэг хэрэгсэл нь үнийн хэлбэлзэл, хураалт бууралт болсоноос үүдэн гарсан орлогын өөрчлөлтийг зохицуулах зорилгоор ашиглагддаг.

С стратеги нь нийлүүлэлт нь эрэлтийг хангаж байхуйцаар үйлдвэрлэл, хадгалалт болон гадаад худалдаанд төрийн зүгээс үзүүлэх оролцоо юм. Тухайлбал, үйлдвэрлэлийн хэмжээг хянах үүднээс зардалд татаас өгөх, эсвэл үйлдвэрлэлийн хэмжээнд хязгаарлалт тогтоож болно. Гадаад худалдааг зохицуулах үүднээс импорт, экспортын хэмжээнд хязгаарлалт тогтоох, татвар авах, татаас өгөх хэрэгслүүдийг ашигладаг. Харин хадгалалтын байдалд нөлөөлөхийн тулд ихэнх улсуудад төрийн нөөцийг бүрдүүлж ашигладаг. Зарим улсуудад хувийн салбарын хөдөө аж ахуйн барааны нөөцөд шууд бус байдлаар зохицуулалт хийх аргууд ч бий.

Д стратеги нь өрх гэрүүдийн үнийн өсөлтөөс үүдсэн хүнсний хомсдлыг зохицуулах зорилготой. Энэхүү стратеги нь үнийн хэт өсөлттэй байгаа үед хамгийн эмзэг бүлгийн өрх гэрүүдэд чиглэдэг бөгөөд төрөөс хүнсний бүтээгдэхүүн тараах хэлбэрээр хэрэгждэг. Гэхдээ энэхүү стратегийн хэрэгслүүд нь тарааж буй бараа (бэлэн мөнгө, ваучер, хоол хүнс г.м), зорилго, тусламжийн хэлбэр (чөлөөт тараалт, татаас г.м), шаардлагатай хувь нэмэр (хүлээн авагч өрх гэрүүд хөдөлмөр эсвэл тодорхой хувь нэмэр оруулах шаардлагатай байх, тухайлбал хүүхдээ сургуульд хамруулах г.м), бүтцийн хувьд (эмзэг өрхийг капиталжуулах) болон онцгой тохиолдол хэрэглэгдэж байна уу гэдгээсээ хамаарч ялгаатай байдаг.

Эдгээр стратегийн хүрээнд үнийг тогтворжуулах, үнийн тогтворгүй байдлын үр нөлөөг арилгах зорилгоор янз бүрийн хэрэгслүүдийг дангаар нь хавсарсан хэлбэрээр ашиглаж болдог. Ингэхдээ тухайн хэрэгслүүд нь үнийн тогтворгүй байдлыг бий болгодог дээр дурьдсан 3 шалтгааны алийг арилгах боломжтой, үнийн тогтворгүй байдал, өрхийн орлого, өрхийн хэрэглээ болон хөрөнгө оруулалтыг хэрхэн өөрчлөх зэргийг нь сайтар харгалзаж үзэх хэрэгтэй юм. Үнэ тогтворжуулах дөрвөн стратегийн хүрээнд хэрэглэгддэг арга хэрэгслүүдийн орлого, хэрэглээ, хөрөнгө оруулалтын алинд илүү нөлөөлдгийг дараах схемээр харуулав.

Схем 4.1. Үнэ тогтворжуулах хэрэгслүүдийн үр нөлөө



Эх сурвалж: F. Galtier (2013) “Managing food price instability in developing countries: A critical analysis of strategies and instruments”, (114-р тал)

Энэхүү схемээс харахад А болон С хэрэгслүүд нь үнэ тогтворжуулах зорилгоор хэрэглэгдэж, үнийн тогтворгүй байдлыг үүсгэж буй 3 гол шалтгаан, үнийн тогтворгүй байдлыг бууруулахад гол анхаарлыг хандуулдаг. Харин В болон D стратегийн хэрэгслүүдийн хувьд үнийн тогтворгүй байдлаас үүдэн гардаг өрхийн орлого, хэрэглээ, хөрөнгө оруулалтын өөрчлөлтүүдийг аль болох багасгах чиглэлд голлон нөлөөлдөг байна. Эдгээрээс В хэрэгслүүдийн нь үнийн тогтворгүй байдлаас хамаарч ХАА эрхлэгчдийн орлого тогтворгүйжих сөрөг нөлөөг бууруулахад чиглэсэн эрсдлийг удирдах санхүүгийн хэрэгслүүд гэдгээрээ онцлог юм. Гэвч эдгээр хэрэгсэл нь хөрөнгийн зах зээл өндөр хөгжсөн улсуудад илүү үр өгөөжөө өгөхөөс биш энэхүү зах зээл нь сул хөгжсөн хөгжиж буй улсуудад богино хугацаанд амжилттай хэрэгжиж чадахгүй билээ. Иймд төрийн тодорхой хэмжээний зохицуулалт бүхий С, D хэрэгслүүдийг зах зээлд тулгуурлан хэрэгжүүлэх А, В хэрэгслүүдтэй зөв хослуулан хэрэглэх шаардлагатай юм. Үүний гол агуулга нь зах зээлийн жамаараа үнэ харьцангуйгаар өөрөө тогтворждог зөв системд шилжихэд А, В хэрэгслүүд нэн хэрэгтэй боловч, эдгээрийг хөгжүүлж, төлөвшүүлэхэд харьцангуй урт хугацаа шаардлагатай. Иймд эдгээр зах зээлийн хэрэгслүүдийг аажмаар хөгжүүлэх бодлогыг баримтлах явцдаа богино болон дунд хугацаанд төрийн зохицуулалт бүхий үнэ тогтворжуулах хэрэгслүүдийг зохистойгоор хэрэглэх замаар үнийн тогтворгүй байдлаас үүдэх макро, микро эдийн засгийн болон бусад сөрөг үр нөлөөг багасгах нь улс орнуудын хувьд хэрэглэгдэж буй нийтлэг стратеги юм.

4.2. Энэтхэгийн үнэ тогтворжуулах сан

Энэтхэг улсын засгийн газар нь 2003 оны 04 сараас 2013 оны 04 сар хүртэл цай, кофе, каучук, тамхины ургамал гэсэн 4 төрлийн газар тариалангийн бүтээгдэхүүний үнийн уналтаас үүдсэн тариаланчдын санхүүгийн хүндрэлтэй байдлыг бууруулах үүднээс “Үнэ тогтворжуулах сан” хөтөлбөрийг батлан хэрэгжүүлсэн.

Уг хөтөлбөрийн гол зорилго нь дээрх газар тариалангийн бүтээгдэхүүний олон улсын зах зээлийн үнэ нь тогтоосон түвшингээс буурсан тохиолдолд хөтөлбөрт хамрагдах тариаланчдад санхүүгийн туслалцаа үзүүлэх, урт хугацааны тогтвортой байдлыг тариаланчдад бий болгох, тэдний эрх ашгийг хамгаалах явдал юм. Хөтөлбөрийн онцлогийг тоймлон харуулбал:

Хүснэгт 4.2 Энэтхэгийн үнэ тогтворжуулах сангийн онцлог

Сангийн хөрөнгө бүрдэлт	- Сангийн үндсэн хөрөнгө 5 тэрбум рупи - Засгийн газрын нэг удаагийн хувь нэмэр 4,83 тэрбум рупи - Тариаланчдын нэг удаагийн хувь нэмэр 171,2 сая рупи (342 мянган тариаланчдын хураамж)
Оролцогчдод тавигдах шаардлага	- Нийт 1,3 сая тариаланчдаас нэн тэргүүнд оролцох шаардлагатай 342 мянган тариаланчид (4 хүртэл га газартай тариаланчид багтсан) орох боломжтой - Хөтөлбөрт оролцох хураамж болох 500 рупи төлөх - Аль нэг банкинд Үнэ тогтворжуулах сангийн данс нээлгэх
Үнийнхүрээ, үйлчлэх хүрээ	- 4 төрлийн бүтээгдэхүүний хувьд адилхан 40% байна - Тухайн бүтээгдэхүүний сүүлийн 7 жилийн олон улсын зах зээлийн үнийн хөдөлгөөнт дундаж суурилан үнийн хүрээг тогтооно - Үнийн доод хүрээ нь ОУ-ын зах зээлийн дундаж үнийн - 20%, дээд хүрээ нь ОУ-ын зах зээлийн дундаж үнийн +20% - Дотоодын үнийг Үнийн хүрээнд харьцуулах замаар Өсөлттэй, Хэвийн, Уналттай жилүүд гэж ангилна ○ Өсөлттэй жил: Дотоодын үнэ нь үнийн дээд хүрээнээс их ○ Хэвийн жил: Дотоодын үнэ нь үнийн дээд, доод үнийн хүрээнд багтаж байх үе ○ Уналттай жил: Дотоодын үнэ нь үнийн доод хүрээнээс бага байх үе
Сангийн хуримтлал болон зарцуулалт	- Өсөлттэй жил: Тариаланч 1000 рупи дансанд хийх ба нөхөн төлбөр авахгүй - Хэвийн жил: Засгийн газар 500 рупи, тариаланч бүр 500 рупи дансанд хийх ба нөхөн төлбөр авахгүй - Уналттай жил: Засгийн газар 1000 рупи дансанд хийх ба

	тариаланч бүр 1000 хүртэлх рупиг нөхөн төлбөр хэлбэрээр авч болно
--	---

Үнэ тогтворжуулах сангийн үндсэн хөрөнгө нь Засгийн газрын төрийн дансанд жилийн 8%-ийн хүүтэйгээр байршдаг бөгөөд сангаас зарцуулалт хийхдээ үндсэн хөрөнгөнд хүрэлгүйгээр жилийн хүүний орлогыг л ашигладаг байна. Энэхүү хүүгийн орлого нь Энэтхэгийн хөгжлийн банк болох Хөдөө Аж Ахуйн Хөгжлийн Үндэсний Банкны удирдлага дор ажилладаг итгэлцлийн сан руу шилжиж, улмаар үнэ тогтворжуулах сангийн үйл ажиллагаанд зарцуулагддаг. Уг итгэлцлийн сангийн үйл ажиллагааг Энэтхэгийн төрийн аудитор хянах ба 5 жил тутамд үйл ажиллагаанд үнэлэлт өгдөг.

Энэтхэгийн энэхүү хөтөлбөр 2013 онд амжилттай хэрэгжиж дуусахад Худалдааны Яамнаас “Тодотгосон үнэ тогтворжуулах сан”-ийн хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж эхэлсэн. Өмнөх хөтөлбөртэй адил бөгөөд зарим дутагдалтай талыг нь сайжруулсан байна. Үүнд:

- Цай, кофе, каучук, тамхины ургамал дээр cardamom хэмээх ургамлыг нэмсэн
- Олон улсын зах зээлийн сүүлийн 5 жилийн хөдөлгөөнт дунджид суурилан үүнийн хүрээг тогтоох
- Өмнөх хөтөлбөрт хамрагдаж байсан тариаланчид хураамж төлөлгүйгээр шинэ хөтөлбөрт шууд шилжих боломжтой
- Өмнөхтэй адил хэвийн болон өсөлттэй жилд тариаланчид нөхөн төлбөр авахгүй. Зөвхөн уналттай жилд шаардлага хангасан тариаланчид тариалан эрхэлж буй 10 га хүртэлх талбайд га тутамд 12,000 рупиг нөхөн төлбөрт авч болох бөгөөд нөхөн төлбөрийн дээд хэмжээ 1 тариаланчийн хувьд 60,000 рупигээс хэтрэхгүй. Хэрэв уналттай жил үргэлжилбэл дараагийн жил нь нөхөн төлбөрийн хэмжээ 15%-иар өснө. Хэрэв 5 жилийн хугацаанд уналттай жил тохиолдохгүй бол нөхөн төлбөр болох 12,000 рупиг (дээд хязгаар нь 60,000 рупи) нэхэмжлэх боломжгүй.
- Тариаланч бүр зураг бүхий АТМ дебит карттай болсноор өмнөх хөтөлбөрийн үед банкинд дугаарлах, бичиг баримт бүрдүүлэх зэрэг аль аль талд учирч байсан хүндрэлүүдийг шийдвэрлэсэн.

4.3. Канадын хөдөө аж ахуйн орлого тогтворжуулах хөтөлбөр

Уг хөтөлбөр нь 2007 оноос Онтарио мужийн санаачлагаар батлагдан хэрэгжиж эхэлсэн. Энэ нь урт хугацааны туршид хэрэгжих фермерийн эрсдлийн удирдлагын хэрэгсэл бөгөөд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний орлогын бага болон их хэмжээний бууралтаас хөдөө аж ахуй эрхлэгчдийг хамгаалах зорилготой юм. Хөтөлбөрийн онцлог нь орлогыг тогтворжуулах болон гамшгийн үеийн тусламжийг хамтад нь цогцоор нь шийдсэн явдал юм.

Гол агуулга нь орлогын алдагдлыг засгийн газар болон хөдөө аж ахуй эрхлэгчид хувааж төлөх ба хэрэв орлого бага хэмжээгээр буурсан үед засгийн газар болон хөтөлбөрт оролцогчид ижил хэмжээгээр уг алдагдлыг нөхнө, харин алдагдлын хэмжээ ихэсвэл засгийн газраас нөхөн төлөх төлбөрийн хувь 4 дахин ихсэх боломжтой. Хөтөлбөрт оролцогчид нь жил бүр оролцооны хураамжийг төлөх ба тухайн жилийн орлого (фермерийн борлуулалтаас зөвхөн үйл ажиллагаатай холбоотой зардлуудыг хассан дүн буюу үйлдвэрлэлийн маржин) нь өмнөх 5 эсвэл 3 жилийн орлогын дунджаас бага тохиолдолд орлогын алдагдал үүссэн хэмээн үзэж нөхөн төлбөр олгодог байна.

Уг хөтөлбөрийн хэрэгжилтийг Онтарио Агрикорп хэмээх Онтарио мужийн хөдөө аж ахуйн салбарт эрсдлийн удирдлагын хөтөлбөрүүд, хөдөө аж ахуйн даатгалыг хэрэгжүүлдэг Хатан хааны нэрэмжит агентлаг хангаж ажилладаг. Энэхүү байгууллага нь хөтөлбөрт оролцогчдын бүртгэл, тэдгээрийн фермерийн орлогын тооцоо, хураамж, нөхөн төлбөрийн хэмжээ зэргийг тооцоолж, олгох ажлыг зохион байгуулдаг.

Хөтөлбөрт оролцох фермерүүдэд нь Канад улсад фермерийн аж ахуйг дор хаяж тасралтгүй 6 сар эрхэлсэн, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг бүрэн циклээр гүйцэтгэдэг, фермерийн орлогын татвар төлж, тайлангаа Канадын Орлогын Агентлагт цаг хугацаанд нь гаргаж өгдөг байх ёстой гэсэн шаардлага тавьдаг. Фермер нь татвар төлдөг хуулийн этгээд болох хувиараа эрхлэх аж ахуй, хязгаарлагдмал нөхөрлөл, корпораци, хоршоолол хэлбэртэй байж болно. Оролцогчид нь нөхөн төлбөр авах түвшингөөсөө хамаарч жилийн хураамжаа төлөх боломжтой. Үүнд 3 төрлийн хамрах түвшин бий:

- Дээд түвшин: тухайн жилийн нийт маржины бууралтын 70 хүртэлх хувийг даатгах. Энэ тохиолдолд жилийн хураамж нь (100% х өмнөх таван жилийн үйлдвэрлэлийн маржины дундаж х 0.45%)
- Дунд түвшин: тухайн жилийн нийт маржины бууралтын 66.5 хүртэлх хувийг даатгах. Энэ тохиолдолд жилийн хураамж нь (85% х өмнөх таван жилийн үйлдвэрлэлийн маржины дундаж х 0.45%)
- Доод түвшин: тухайн жилийн нийт маржины бууралтын 56 хүртэлх хувийг даатгах. Энэ тохиолдолд жилийн хураамж нь (70% х өмнөх таван жилийн үйлдвэрлэлийн маржины дундаж х 0.45%)


Мөн хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагааны зардалд оролцогч бүрээс жилд 55 канад долларыг суутгадаг.

Хөтөлбөрөөс хүртэх нөхөн төлбөрийн хувьд тухайн жилийн маржин нь өмнөх 5 жилийн дундаж маржинаас доогуур болбол тухайн оролцогчийн төлсөн хураамж, сонгосон нөхөн төлбөрийн түвшингөөс хамаарч олговрыг дараах үеээр олгоно:

- Нэгдүгээр үе: Тухайн жилийн маржин нь өмнөх 5 жилийн дундаж маржинаас 15%-иар буурахад маржины алдагдлын 50%-ийг Засгийн газар төлнө.

- Хоёрдугаар үе: Тухайн жилийн маржин нь өмнөх 5 жилийн дундаж маржинаас 15-30%-ийн уналттай үед маржины алдагдлын 70%-ийг Засгийн газар төлнө.
- Гуравдугаар үе: Тухайн жилийн маржин нь өмнөх 5 жилийн дундаж маржинаас 30%-иас дээш уналттай үед маржины алдагдлын 80%-ийг Засгийн газар төлнө.
- Дөрөвдүгээр үе: Тухайн жилийн маржин нь сөрөг гарвал уг сөрөг дүнгийн 60%-ийг Засгийн газар төлнө (Зураг 3)

Схем 4.2. Канадын орлого тогтворжуулах хөтөлбөр дэх Засгийн газрын оролцоо



Дэлхийн II дайны дараах Тайваны ХАА-н бодлого нь 1969 он хүртэлх болон түүнээс хойших гэсэн 2 үндсэн үе шаттай байв. Эхний үед үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хүнсний бүтээгдэхүүний бодит үнийг технологи, институцийн шинэ санаачлагын үндсэн дээр бууруулахад ХАА-н бодлогууд нь чиглэж байсан. Харин 1969 оноос хойш дотоодын зах зээлд ХАА-н болон ХАА-н бус салбарын орлогын ялгаа ихэссэн, олон улсын зах зээл дээр Тайваны аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний экспорт эрс өссөнөөр гадаад худалдааны тэнцэл нь эерэг болж, улмаар гаднаас импортлох хямд үнэтэй ХАА-н бүтээгдэхүүний хэмжээ нэмэгдсэнээс дотоодын ХАА эрхлэгчдэд хүнд цохилт болсон. Иймд үндэсний ХАА-н салбарыг хөгжүүлэх, ХАА эрхлэгчдийн орлого, баялагийг нэмэгдүүлэх, дотоодын хүнсний хэрэгцээгээ өөрсдөө хангадаг болох зорилгоор засгийн газраас нь төрөл бүрийн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ ХАА-н хөгжлийн хуулийг 1973 онд батлан мөрдсөн байна. Үнэ болон орлогыг тогтворжуулах бодлогуудын гол хэрэгслүүд нь үнийг дэмжих, үнэ тогтворжуулах, шууд төлбөр болон зардалд олгох татаас зэрэг байв. Эдгээрийг дараах хүснэгтэнд нэгтгэн харуулав.

Хүснэгт 4.3. Тайваны ХАА-н бодлогын ерөнхий бүтэц

№	Бодлогын хүрээ	Зорилго	Гол төсөл/арга хэмжээнүүд
1	Бүтцийн бодлого	- Фермүүдийн хэмжээг өргөжүүлэх - Фермерүүдийн хоршилтыг дэмжих	- ХАА-н газрын шинэчлэлийн хөтөлбөрийн 2 дахь үе шат - Фермийн газрыг худалдан авах хөтөлбөр - Бүсийн төлөвлөлтийн хөтөлбөр - Цөм фермерийн хөтөлбөр - Хөдөөгийн аж үйлдвэржилтийг дэмжих хөтөлбөр
2	Үйлдвэрлэлийн бодлого	- ХАА-н үйлдвэрлэлийн бүтцийг зохицуулах - Үр ашгийг нэмэгдүүлэх - ХАА-н дэд бүтцийг сайжруулах	- Цагаан будааны тариалангийн талбайг хамгаалах хөтөлбөр - Судалгаа - Усжуулалт болон газрын нөөцийн хөтөлбөр - Фермийн техник, технологийг шинэчлэх хөтөлбөр - Хөдөөд чиглэсэн төсвийн хөрөнгө оруулалт
3	Үнэ болон орлогын бодлого	- Үнийг тогтворжуулах болон дэмжих - Фермер өрхийн орлогыг нэмэгдүүлэх	- Цагаан будаа, жижиг үр тариа, сахар болон гол тарианы үнийг дэмжих хөтөлбөрүүд - Импортын үр тарианы үнийг тогтворжуулах хөтөлбөр - Малын даатгал - ХАА-н хөгжил, зээлийн хөтөлбөр - Хилийн арга хэмжээ - Шууд төлбөр
4	Маркетингийн бодлого	- Маркетингийн сувгуудыг оновчтой болгох - Хүнсний бүтээгдэхүүний чанарыг сайжруулах	- ХАА-н маркетингийн хууль - Хүнсний бүтээгдэхүүний боловсруулалтыг хөгжүүлэх хөтөлбөр - Хамтарсан маркетингийн хөтөлбөр - Бөөний захын

			шинэчлэлийн хөтөлбөр
5	Хөдөөгийн амьдралын бодлого	- Хөдөөгийн тосгодын хүрээлэн буй орчины хүчин зүйлсийг сайжруулах - ХАА эрхлэгчдийн баялагийг нэмэгдүүлэх	- Фермерүүдийн эрүүл мэндийн даатгалын хөтөлбөр - Хөдөөгийн тосгодыг дахин зохион байгуулах хөтөлбөр - Фермерүүдийн дэлгүүр, төвүүдийг байгуулах

Эх сурвалж: Ts. Peng (1991) “Price stabilization measures and their impacts”, 102-р тал

Эдгээрээс үнэ болон орлого тогтворжуулах хөтөлбөрүүдийг авч үзвэл ХАА-н гол нэр төрлийн бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах зорилгоор Тайваны засгийн газраас гурил, шар буурцаг, эрдэнэ шишийн нөөцийн сан; жижиг ХАА эрхлэгчдэд бүтээгдэхүүнээ боломжийн үнээр худалдахад нь туслах зорилгоор дотоодын зах зээлийг тогтворжуулах сан зэргийг байгуулжээ.

а.Импортын бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах сан: Хүнсний тос, гурил, малын тэжээлийн үйлдвэрлэлд хэрэглэгддэг түүхий эдийн 90 гаруй хувийг импортолдог байсан тул эдгээрийн олон улсын зах зээл дээрх үнийн хэлбэлзэл нь дотоодод үйлдвэрлэх хүнсний бүтээгдэхүүний үнийг ихээхэн хэлбэлзэхэд хүргэж байв. Иймд зарим жижиг үр тарианд импортын квот, засгийн газраас олгосон лицензээр худалдан авах, түүхий эдүүдийг багцлан “нэгдсэн импортын үнэ”-ийн тогтолцоонд багтааж эдгээрийг худалдан авагч дотоодын хэрэглэгчид нь олон улсын барааны зах зээлийн үнэд суурилан тогтоосон тогтворжсон үнийг төлөх боломж олгосон.

б. Үйлдвэрлэгчийн маркетингийн үнийг тогтворжуулах сан: Үр тарианы үнийг бодвол гахай, загасны мах, хүнсний ногоо, жимсний үнэ нь илүү хэлбэлзэлтэй байдаг тул жижиг фермерүүд бүтээгдэхүүнээ ашигтай худалдахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор фермерүүдийн холбоо, маркетингийн хоршоодын оролцоотойгоор эдгээр бүтээгдэхүүнд зориулан хамтарсан маркетингийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсэн. Эдгээр холбоодын зорилго нь хамтарсан маркетинг хийх замаар маркетингийн нэгжийн зардлыг бууруулах, үйлдвэрлэгчдийн хувьд боломжийн үнээр бүтээгдэхүүнээ худалдаалах, их хэмжээний борлуулалт хийн үйлдвэрлэгчид болон худалдаачдын хооронд бат бөх харилцаа үүсгэх явдал байв. Фермерүүдийн худалдах үнийг тогтворжуулахын тулд төрөл бүрийн бөөний худалдааны захуудын үнийн дунджид суурилсан баталгаат үнийг тогтоосон. Уг хөтөлбөрт оролцогч фермерүүд тогтворжуулалтын санд хураамж төлж, шаардлагыг нь хангасан тохиолдолд баталгаат үнэд хамрагддаг. Энэхүү сан нь засгийн газрын дэмжлэгтэй бие даан санхүүжилтээ шийдвэрлэдэг бөгөөд зах зээлийн зуучлагчид, фермерүүдийн холбоо нь сангийн хөрөнгийн тодорхой хэсгийг бүрдүүлж, хувь нэмэр оруулдаг байна.

в. Шууд төлбөр төлөх хөтөлбөр: Баталгаат өндөр үнэ, цагаан будааны дотоодын хэрэглээний буурсан, экспортын квоттой байсан зэргээс хамаарч цагаан будааны

үйлдвэрлэлийн илүүдэл бий болсон. Иймд 1980-д онд тариаланчдын эрх ашгийг хохироолгүйгээр цагаан будааны тариалалтыг бууруулж, тариалангийн талбайд эрдэнэ шиш мэтийн эрэлт ихтэй өөр ургамлын тариалалтыг дэмжих бодлого баримталжээ. Засгийн газраас цагаан будааны оронд эрдэнэ шиш, шар буурцаг, сорго зэргийг тариалах санаачилга гаргасан тариаланчдад өөр ургамал тарихтай холбоотой гарах эрсдлийг нь бууруулах зорилгоор биет төлбөр болох цагаан будааг олгох болов. Үүнд: дээрх 3 ургамлыг тариалбал 1000 кг цагаан будаа, хүнсний ногоо, жимс таривал 1500 кг, тариалангийн талбайд ургамал тарилгүй нөөцөлвөл 1500 кг цагаан будааг нөхөн төлбөр байдлаар олгож байв.

г. Зардалд татаас олгох хөтөлбөр: Үйлдвэрлэлийн зардал болон санхүүгийн дарамтыг бууруулахын тулд ХАА-н татварын системийг боловсронгуй болгосон. Мөн ХАА-н үйлдвэрлэлд гарах эрчим хүчний зардлын тодорхой хэсгийг засгийн газраас татаас хэлбэрээр хөнгөлж, фермерүүдийг шинэ технологи нэвтрүүлэх, байгаа нөөцөө үр ашигтай ашиглах байдлыг нь дэмжих зорилгоор зээлийн шинэ системийг хэрэгжүүлжээ. Ингэснээр тодорхой хөтөлбөрийн хүрээнд засгийн газраас бага хүүтэй, уян хатан нөхцөлтэй зээлийг фермерүүдэд олгож байв.

Тайваны үнэ тогтворжуулах хөтөлбөрүүдийн онцлог нь цагаан будаанаас бусад үр тариа, хүнсний ногоо, жимсний үнийг тогтворжуулах хөтөлбөрүүд нь засгийн газраас эхэлж санаачилсан ч аажмаар санхүүгийн хувьд бие даасан байдалд шилжсэн явдал юм. Эдгээрийг ихэвчлэн фермерүүдийн хоршоо, холбоод удирдан явуулдаг байна.

Бүлэг-5. Дүгнэлт, санал, зөвлөмж

5.1. Дүгнэлт

1.Шинэчлэлтийн Засгийн газраас үйл ажиллагааны хөтөлбөртөө тодорхойлсон “инфляцид хөтлөгдөх бус зохицуулах тогтолцоонд шилжих”, “инфляцийг нэг оронтой тоонд барьж, төгрөгийн худалдан авах чадварыг тогтвортой байлгах” зорилтууд 2012-2014 оны байдлаар үндсэндээ хэрэгжээгүй явж ирлээ.Төгрөгийн худалдан авах чадвар 2012-2014 онд 40-өөд хувиар унаад байна.

2.Монголбанкнаас “Төрөөсмөнгөнийбодлогынталаар 2012 ондбаримтлахүндсэнчиглэл”-д тодорхойлсон ХҮИ-ээрилэрхийлэгдэхинфляцийгнэгоронтойтооноосхэтрүүлэхгүй байх,2013-2014онуудадинфляцийг 8 хувиас хэтрүүлэхгүй түвшинд байлгана гэсэн зорилт амьдралд огт хэрэгжээгүй. ХҮИ-ээрилэрхийлэгдэхинфляцийн өсөлт 2012 онд 14 хувь, 2013 онд 12.5 хувь байсан бөгөөд энэ 2014 онд мөн 2 оронтой тоогоор өсөх нь тодорхой болоод байна.

3.Монгол Улс шилжилтийн эдийн засагтай орнуудын дотор инфляцийн өсөлт хамгийн өндөртэй эхний 7 орны тоонд орж байна.

4.Манай орны хүнсний бараа, бүтээгдэхүүний үнэ 2008 оноос хойш дэлхийн зах зээл дэх хүнсний бүтээгдэхүүний дундаж үнээс хурдацтай нэмэгдсээр ирсэн байна. Ялангуяа үхрийн махны үнэ дэлхийн зах зээлийн үнээс ч хурдан өссөн нь анхаарал татаж байна.

5.Хэрэглээний үнээр тооцсон инфляци болон мөнгөний хүчин зүйлээс хамааралтай суурь инфляци хоёрын хоорондох зөрүүгээс харахад манай оронд эрэлтийн болон нийлүүлэлтийн шинжтэй хүчин зүйлинфляцид ихээхэн нөлөөтэй байна. Энэ нь мөнгөний бус хүчин зүйлс инфляцид их нөлөөтэйг харуулсан тул инфляцийг тогтворжуулахад Засгийн газрын оролцоо чухал байна.

6.Инфляци өндөр хурдацтай өсгөж ирсэн гол шалтгааныг сүүлийн 2 жилд валютын ханшны өсөлттэй холбон тайлбарлах явдал түгээмэл байгаа боловч судалгаа болон ХҮИ-ийн тооцооноос үзэхэд 2013 оны инфляцийн 12.5 хувийн өсөлтийн 2 хувь л импортын барааны өсөлтөөс болсон, харин 2014 оны эхний 8 сарын байдлаар импортын барааны үнийн өсөлт инфляцид бараг нөлөөлөөгүй дүн гарлаа. Инфляцийн өсөлтөд гол нь мөнгөний нийлүүлэлтийн хэмжээ ихээр нэмэгдэн, төсвийн зардал их өсөж, алдагдал нь нэмэгдсээр ирсэн явдал илүү хүчтэй нөлөөлсөн байна.

7.Монголбанкнаас сүүлийн жилүүдэд эдийн засгийн өсөлт, тэлэлтийг дэмжсэн мөнгөний бодлого явуулж, мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлсэн нь инфляци өндөр хурдацтай өсөх нөхцөлийг бүрдүүлжээ.

8.Хүн амынхаа амьжиргааг дордуулж, эдийн засгаа өсгөх үү, аль эсвэл эдийн засгийн өсөлтөө зохих түвшинд барьж, хүн амынхаа амьжиргааг дордуулахгүй байх уу гэдэг 2 сонголтын эхнийхээр нь үндсэндээ явж иржээ. Эдийн засгийн үр ашиг багатай өсөлтөөсөө хүн амын амьжиргаа нь чухал байсан байж болох талтай.

9.Манай орны онцлогоос урган гарсан инфляцид нөлөөлдөг нэг онцлог шалтгаан бол хүнсний бүтээгдэхүүний үнэ 2008 оноос хойш байнга харьцангуй өндөр хурдацтай өссөн, хамгийн их тогтворгүй, улирлын ихээхэн хэлбэлзэлтэй байгаанын инфляцийн өсөлтөд голлон нөлөөлж ирсэн байна. 2008 оноос хойш хүнсний бүтээгдэхүүний үнийн өөрчлөлтийг ХҮИ дагаж өөрчлөгдөж ирсэн нь энэхүү судалгаанаас тодорхой харагдаж байна. Хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлтийн инфляцийг хөөрөгдөх гол дарамт хэвээр байна.

10.Хүнсний бүтээгдэхүүний үнэ улирлын хэлбэлзэлтэй байгаа нь түүний улирлын шинжтэй нийлүүлэлтээс үүдэлтэй байна. Жилийн тодорхой улиралд нийлүүлэлт нь нэмэгдэж, зарим улиралд нь хомсдол үүсэж байгаа нь үнэд нөлөөлж ирсэн. Нийлүүлэлтийн шинжтэй энэхүү нөлөөг гагцхүү Засгийн газар л голлон зохицуулах боломжтой билээ.

11.Засгийн газар Монголбанкт хамтран хэрэгжүүлж байгаа “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөр” –ийн хэрэгжилтийн явцаас үзэхэд шатахуун болон гурилын үнийг тогтворжуулах талаар тавьсан зорилгодоо үндсэндээ

хүрсэн боловч бусад нэр төрүүдийн хувьд ихээхэн хэмжээний хөрөнгө зарцуулсан боловч тавьсан зорилгодоо хангалттай хүрээгүй байна.

12.Засгийн газар Монголбанктай хамтран инфляцийн өсөлтийг тогтворжуулахад оролцдог болсон нь сайшаалтай шинэ хандлага юм. Гэхдээ үнэ тогтворуулах хөтөлбөрөөсөө илүүтэй төсвийн зардлаа багасгах арга замаар инфляцид нөлөөлөх нь илүү үр дүнтэй байсан.

5.2. Санал, зөвлөмж

1. Засгийн газар 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөртөө инфляцид хөтлөгдөх бус зохицуулах тогтолцоонд шилжих талаар дэвшүүлсэн зорилтоо хэрэгжүүлэхийн тулд Монголбанктай хамтарч мөнгөний болон макро эдийн засгийн бодлогодоо эрс өөрчлөлт хийх шаардлагатай байна. Үүнд:

1.1.Эдийн засгийн өсөлт, тэтгэлтийг дэмжсэн мөнгөний бодлогоо чангатгаж, мөнгөний нийлүүлэлт хурдацтай өсөж ирснийг хязгаарлах бодлого явуулахыг зөвлөж байна.

1.2.Төсвийн тогтвортой байдлын хуулийг чанд сахиж, төсвийн алдагдлыг эрс бууруулах, төсвийн зардлыг бүх чиглэлээр багасгах, төсвөөс гадуурх эх үүсвэрээр санхүүждэг Засгийн газрын зардлуудыг төсөвт тусгах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг санал болгож байна.

2.Засгийн газар хүнсний бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлтийг тогтвортой байлгах, түүний нийлүүлэлтийн улирлын шинжтэй хэлбэлзлийг арилгахад голлон анхаарахыг зөвлөж байна.

3.Үнэ тогтворжуулах талаар бусад улс орнуудад хэрэгжүүлсэн арга хэрэгсэл, туршлагыг сайн судлаж үзэх шаардлагатай байна. Монгол Улсад үнийн арбитражийг бий болгох асуудлыг тусгайлан судлахыг санал болгож байна.

4.“Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөр”-өөс хүнсний бараа, бүтээгдэхүүний улирлын шинжтэй нийлүүлэлтийг багасгахад чиглэсэн “Хүнсний бүтээгдэхүүний зоорь, агуулахыг нэмэгдүүлэх, эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх” хөтөлбөр урт хугацаандаа үр ашгаа өгөхөөр чухал гэдэг нь энэхүү судалгаанаас харагдлаа.

5.Өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэд нөлөөлдөг субъектив хүчин зүйлсийн нөлөөлийг багасгахын тулд хөгжингүй орнуудад үйлчилдэг бусад хуулиуд, тухайлбал, үнэд хяналт тавих тухай, үнийн зохицуулалтын тухай, худалдааны тухай хууль, бүтээгдэхүүний үнэ бүрдэлтийн тухай хуулиудыг судлаж өөрийн орны хууль эрх зүйн орчингоо сайжруулахыг санал болгож байна.

6.Монголын үйлдвэрчний эвлэлүүдийн холбооноос санал болгож байгаа бүтээгдэхүүний үнэ бүрдэлтийн тухай хуулийг анхааралдаа авахыг санал болгож байна.

7.Манай орны хувьд бөөний худалдааг эрхлэх зөвшөөрлийг бараа, бүтээгдэхүүнийхээ хилийн болон дотоодын үнийг төрийн онцгой хяналтанд байлгах нөхцөлтэйгөөр зохих

шаардлага хангасан, цөөхөн компаниудад олгохыг хуульчлан тогтоож өгөхийг санал болгож байна.

8.Жижиглэн худалдаа эрхлэгчид зөвхөн бөөний худалдаанаас бараа, бүтээгдэхүүнээ авдаг журамд оруулж, жижиглэнгийн худалдаачдыг өөрсдөө импортоор өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүн оруулахыг хориглохыг хуульчлан тогтоож өгөхийг санал болгож байна.

9.Олон улсын практикын дагуу жижиглэн худалдааны цэг, салбар, дэлгүүр нь бөөний худалдааны баазаас авсан барааны үнэ дээр 20 хүртэл хувийн худалдааны нэмэгдэл нэмж, жижиглэн худалдааны үнээ тогтоодог болгож, хүн амын өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнэнд төрөөс үр ашигтай хяналт тавих боломжийг хуульчлан тогтоож өгөхийг санал болгож байна.

Ашигласан материалууд

1. Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр
2. Монголбанк, Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэл, 2012, 2013, 2014 он
3. Монгол Улсын Засгийн газар Монголбанктай 2012 оны 10 дугаар сарын 22 –нд байгуулсан “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөр”-ийг хамтран хэрэгжүүлэх харилцан ойлголцлын санамж бичиг
4. Монголбанкны Ерөнхийлөгч болон Уул уурхайн сайдын 2012 оны 10 дугаар сарын 26-ний өдрийн хамтарсан тушаалаар баталсан “Шатахууны жижиглэнгийн үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөр
5. Монголбанкны Ерөнхийлөгч болон Зам, тээврийн сайдын 2012 оны хамтарсан тушаалаар баталсан “Өргөн хэрэглээний импортын бараа, бүтээгдэхүүний өртгийг бууруулах” дэд хөтөлбөр
6. Монголбанкны Ерөнхийлөгч болон Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын хамтарсан тушаалаар 2012 оны 10 дугаар сард баталсан “Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөр
7. Монголбанкны Ерөнхийлөгч болон Барилга, хот байгуулалтын сайдын 2013 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн хамтарсан тушаалаар баталсан “Барилгын салбарыг дэмжих, улмаар орон сууцны үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөр
8. (Eckstein1981)
9. Haldane 1995; Neumann and von Hagen 2002
10. <http://www.docstoc.com/docs/68851283/What-is-core-inflation-Flow-of-Funds>

11. Б.Энх-Амгалан, Б.Батмөнх, “Монгол Улсын хэрэглээний үнийн индексэд хүнсний бүтээгдэхүүний үнийн үзүүлэх нөлөө болон олон улсын туршлага”, АХБ-наас санхүүжүүлсэн судалгааны ажлын тайлан, 2014 он
12. Ч.Энхбаяр, Г. Пүрэвсүрэн “Монголын санхүүгийн системийн өнөөгийн байдал, санхүүгийн систем дэх гадаадын шууд хөрөнгө оруулалтыг шингээх чадвар”, МУИС, ЭЗС-ийн “ЭДИЙН ЗАСАГ: онол, практик” сэтгүүл, 2011 №369
13. World bank, World Development Indicators-2013,
14. Д.Ган-Очир, Монголын эдийн засаг дахь мөнгөний өсөлт болон инфляцийн хамаарал, 2009
15. Монгол Улсын Статистикийн эмхэтгэл, 2005, 2012, 2013
16. Л.Даваажаргал, Мөнгөний өсөлт ба инфляцийн хоорондох хамаарал, 2005
17. Д.Ган-Очир, Монголын эдийн засагт мөнгө урт хугацаанд нейтраль уу?, 2008
18. Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилтийн тухай үндэсний 5 дахь илтгэл, 2013 он
19. 2006-2014 оны сар бүрийн бюллетень
20. www.mongolbank.mn
21. F. Galtier (2013) “Managing food price instability in developing countries: A critical analysis of strategies and instruments”
22. F. Galtier (2013) “Managing food price instability in developing countries: A critical analysis of strategies and instruments”,
23. “Канадын хөдөө аж ахуйн орлого тогтворжуулах хөтөлбөрийн гарын авлага”, 15-р тал (Canada-Ontario Initiative, 2007)
24. Ts. Peng (1991) “Price stabilization measures and their impacts”